

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

**“УЛИАСТАЙ-АЛТАЙ ЧИГЛЭЛИЙН АВТО
ЗАМЫН УЛИАСТАЙ ЦАГААНХАЙРХАН
ХЭСГИЙН 40.9 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ
АВТО ЗАМ БАРИХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2025 он

АГУУЛГА

I. ТАНИЛЦУУЛГА	2
1.1. Ерөнхий мэдээлэл	2
1.2. Хүчин чадал	5
1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал	7
II. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	18
2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, биелэлт	18
III. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	21
IV. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	21
V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	21
VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	21
VII. ОСОЛ ЭРСДЭЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ, БИЕЛЭЛТ	21
VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ	22
IX. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ	23
X. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	24
10.1. Танилцуулга	24
10.2. Байгаль орчны хяналтын төлөвлөгөө, шаардлага	24
10.3. Агаар чанарын мониторинг	24
10.4. Газрын гадарга, хөрсний мониторинг	24
10.5. Усны мониторинг	25
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэхэд гаргасан зардал	25
ХАВСРАЛТУУД	26

I. ТАНИЛЦУУЛГА

1.1. Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

“Улиастай-Алтай чиглэлийн авто замын улиастай Цагаанхайрхан хэсгийн 40.9 км хатуу хучилттай авто зам барих” төсөл

Төсөл хэрэгжүүлэгч:

“Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын III үе шатны төсөл”

Гүйцэтгэгч:

“Чайна Жиангсу интернэйшнл Экономик энд техникал корпорэйшн групп” ХХК

Регистрийн дугаар:

9942661

Утас:

976-89955660

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо Ерөнхий сайд Амарын гудамж, 22-р байр, Лагшан төв, 5 давхар, 502 тоот

Төслийн зорилго:

Завхан-Говь-алтай аймгийг холбох авто замын төслийн Алдархаан-Цагаанхайрхан чиглэлийн авто замын энэхүү чиглэл нь орон нутгийн тээврийг оновчтой зохион байгуулах, ачаа болон зорчигч эргэлтийг нэмэгдүүлэх, хөрсний элэгдлийг бууруулах, аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилготой.



Зураг 1. Замын трасс

Төлөвлөж буй Улиастай- Цагаанхайрхан чиглэлийн хатуу хучилттай авто зам нь улсын чанартай А1103 авто зам байх бөгөөд Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Булгийн хошуунаас эхэлж Баянхонгор-Алтай чиглэлийн улсын чанартай А0303 автозамтай нийлэхээр төлөвлөж байна.

Үндэслэл

- Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуулийн 2-р хавсралт, XV.1.1.67-д тусгагдсаны дагуу
- ЗТХЯ-ны 2022 оны 06 сарын 24 ны Замын трасс сонголтын тухай 03/2959 албан тоот
- Завхан аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 05 сарын 24 өдрийн 6/560 “санал өгөх тухай албан тоот”
- Завхан аймгийн Алдархаан сумын засаг даргын 2022 оны 05 сарын 24 өдрийн А/77 тоот “авто замын зурвас газрыг олгох тухай” захирамж
- Завхан аймгийн Цагаанхайрхан сумын засаг даргын 2022 оны 05 сарын 22 өдрийн А/62 тоот “авто замын зурвас газрыг олгох тухай” захирамж
- Завхан аймгийн засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Авто замын барих гүйцэтгэгч нь “Чайна Жиангсу интернэйшнл Экономик энд техникал корпорэйшн групп” ХХК



Зураг 2. Төсөл хэрэгжих талбай


Авто замыг төлөвлөх төлөвлөлтийн стандартуудыг сонгохдоо хөдөлгөөний эрчим, замын зэрэглэл, газар нутгийн байдал зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үздэг. Бүх геометр төлөвлөлтийг хийхдээ “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 мөрдлөг болгосон. Төлөвлөж буй замын техникийн ангилал, зэрэг нь “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 стандартын дагуу хуримтлуулагч зам – 2А байна.

Хуримтлуулагч зам – 2А

Хуримтлуулагч замын үүрэг нь хэд хэдэн бүс, нутаг дэвсгэрээр өнгөрөх замын болон дүүргийн доторхи мөн томоохон суурин газруудын хөдөлгөөний хэрэгцээг хангахад чиглэгдсэн бөгөөд дараах шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байна.

Хүн ам – 1000-аас дээш хүн амтай суурин болон жуулчдын зорьдог газруудын хэрэгцээг хангах.

Хөдөлгөөний эрчим – Жилийн хоногийн хөдөлгөөний дундаж эрчим 200-аас дээш, үүний 35-аас илүүгүй хувийг ачааны машин болон амралт, аялал, зугаалгаар яваа тээврийн хэрэгсэл эзлэх. Зам дээр өнгөрөх тээврийн хэрэгслийн 35-аас илүү хувийг ачааны машин болон амралт, аялал, зугаалгын зориулалттай тээврийн хэрэгсэл эзлэх бол уг замыг 2Б зэрэглэлийн /хуримтлуулагч, тусгай зам/ замд тооцно.



Зураг 3. Замын нэг маягийн хөндлөн огтлол

Хүснэгт 1. Төслийн техникийн үзүүлэлт

№	Ажлын нэр	Хэмжих
1	Замын зэрэг	2А
2	Замын урт	40.9 км
3	Тойруугийн тоо	31
4	Тооцоот хурд км/цаг	80
5	Зурвасын тоо	2м
6	Зурвасын өргөн	3.5м
7	Зорчих хэсгийн өргөн	7м
	Хөвөөний бүрэн өргөн	2м
	Бэхэлгээний хөвөө	0.5
	Явган хүний зам	
	Ногоон байгууламж	
	Замын далангийн өргөн	11м

	Хамгийн их дагуу налуу	69.8%
	Дагуугийн хамгийн их налууугийн үргэлжлэх урт	324м
	Хэвтээ муруйн хамгийн бага радиус	250м
	Хэвтээ муруйн хамгийн их радиус	6000м
	Тойруугийн нийт урт	11.75м
	Босоо гүдгэр муруйн хамгийн бага радиус	4500м
	Босоо гүдгэр муруйн хамгийн их радиус	38000м
	Босоо хотгор муруйн хамгийн бага радиус	3000м
	Босоо хотогр муруйн хамгийн их радиус	40000м

1.2. Хучин чадал

Хүснэгт 2. Үндсэн тоног төхөөрөмж, Техник хэрэгслийн мэдээлэл

№	Машин механизм.тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг
1	Бульдозер	4
2	Экскаватор	4
3	Экскаватор	4
4	Ачигч	6
5	Грейдэр	3
6	Доргиурт индүү	6
7	Автосамослав / Sino Truck	23
8	Усны машин	5
9	Шатахууны машин	1
10	Асфальт дэвсгэгч	2
11	Резинен дугуйтай индүү	2
12	Булт индүү	2
13	Чулуу бутлуурын үйлдвэр	1
14	Асфальт холих үйлдвэр	1
15	Бетон зуурмагийн үйлдвэр	1
16	Бетон зуурагч	4
17	Бетон насос	2
18	Бетон зуурмаг тээвэрлэгч	3
19	Трайлер	2
20	Тэсэлгээний тоног төхөөрөмж	2
21	Генератор	1
22	Генератор	1

23	Генератор	2
24	Генератор	2
25	Генератор	2
26	Генератор	3
27	Генератор	3
28	Генератор	3
29	Кран	1
30	Кран	1
	Нийт	97

Хүснэгт 3. Хүн хүчний мэдээлэл

№	Хүн хүчний мэдээлэл	Тоо ширхэг
1	Төслийн менежер	1
2	Төслийн дэд удирдагч	1
3	Ерөнхий инженер	1
4	Оффис менежер	1
5	Санхүүгийн ажилтан	1
6	Худалдааны мэргэжилтэн	1
7	Хиймэл байгууламж, гүүрийн инженер	1
8	Хиймэл байгууламж, гүүрийн инженер	1
9	Авто зам хучилтын инженер	1
10	Чанарын инженер	1
11	Материалын инженер	2
12	Хэмжилтийн инженер	2
13	Хөдөлмөр хамгааллын инженер	1
14	Үйлдвэрийн инженер	2
15	Механикч инженер, техникч	6
16	Лабораторийн техникч	2
17	Анхны тусламжийн эмч	1
18	Байгаль орчны мэргэжилтэн	1
19	Хэмжилтийн техникч	2
20	Мастер	4
21	Оператор, жолооч	115
22	Техникийн засварчин	88
23	Монгол оператор, жолооч	95

	Нийт	331
--	------	-----

1.3. Төсөл хэрэгжих орчны дэд бүтцийн хөгжлийн байдал



Зураг 4. Карьерын байршил



Зураг 5. Бутлуурын үйлдвэр, тоосжилтыг буурах зорилгоор бороожуулах процесс



Зураг 6. Бетон зуурмагийн үйлдвэр



Зураг 7. Зам талбайн усалгаа хийгдэж байгаа байдал



Зураг 8. Завхан аймгийн Цагаанхайрхан сумын засаг дарга, байгаль хамгаалагч нартай уулзан, хамтран ажиллах талаар төлөвлөж байгаа байдал

Цэвэр ус, Бохир ус:

Техникийн хэрэглээнд ашиглах усыг Богд, Яруу, Ширээгийн голоос татан авч хэрэглэх ба унд ахуйн цэвэр усыг гүний худаг гарган ашиглаж байна.

Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалын 12 дугаар хавсралтан дээр үндэслэн тооцов.

Ажилчдын унд, ахуйн хэрэглээний усыг гүний худгаар хангаж байна. Ажилчдын эрүүл мэндийг хамгаалахын тулд ундны усны эрүүл ахуйн шаардлага MNS 0900:2018 стандартын үзүүлэлтэд нийцсэн нь шинжилгээгээр тогтоогдсон. Гүний худгаа тоолууржуулан, паспортжуулсан бөгөөд ус ашиглах гэрээ байгуулан, төлбөр тооцоог тухай бүр төлж барагдауулан ажиллаж байна.

Цахилгаан:

Авто замын барилгын ажлын үед тухайн кемп дээр дизель генератор ашиглахаар төлөвлөж байна. Мөн тухайн генераторыг байрлуулахдаа суурь хэсгийг цементэлж тос болон түлш нэвччихээгүйгээр байрлуулах шаардлагатай.

Хог хаягдал:

Ахуйн хог хаягдлыг кемпийн хогийн цэгт байршуулан тухайн сумтайгаа гэрээ байгуулах хог хаягдлыг өөрсдийн техник автомашиныг ашиглан сум орон нутгийн хог хаягдлын цэгт ачуулан зайлуулж байна.

Харилцаа холбоо:

Завхан аймгийн Алдархаан сум, Цагаанхайрхан сумын нутагт байрлаж байгаа учир үүрэн телефоны бүх операторын сүлжээтэй байна.

Зам

Зам барилгын ажлын явцад БНбд 32-02-00 “Автозам барих”, “Автозамын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” MNS 4596:2014, “Автозамын тэмдэг. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4597:2014 стандартын дагуу түр замаар зорчиж буй тээврийн хэрэгсэлд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулан, олон салаа зам үүсэх, тоосжилт бий болохоос сэргийлэхээр төлөвлөн ажиллаж байгаа, одоогоор тэмдэг тэмдэглэгээ байршуулаагүй байгаа.



Зураг 9. Ажилчдын кемп орчмын байдал

“Улиастай-Алтай чиглэлийн авто замын улиастай Цагаанхайрхан хэсгийн 40.9 км хатуу хучилттай авто зам барих” төслийн 2025 оны БОМТ биелэлтийн тайлан



Зураг 10. Зааварчилгаа



Зураг 11. Эрэг нурахаас хамгаалсан далан, тууз



Зураг 12. ХХАА-ны зааварчилгаа, сургалт явуулж байгаа байдал



Зураг 13. Автозогсоол



Зураг 14. Автозасвар үйлчилгээний байгууламж



Зураг 15.Түлш олгох цэг ба тухай цэгт аянга зайлуулагч байрлуулсан байдал



Зураг 16. Үерийн далан байгуулсан байдал



Зураг 17. Гүний худаг, тоолууржуулж, хамгаалалтын бүс тогтоосон байдал



Зураг 18. Ус хуримтлуулах байгууламж



Зураг 19. Хог хаягдлыг савыг ажилчдын байранд байрлуусан байдал



Зураг 20. Хатуу хог хаягдын байгууламжийг барих явц /одоогоор баригдаж дуусаагүй байгаа/



Зураг 21. Аюултай хог хаягдал цуглуулах цэг



Зураг 22. Бохир ус хуримтлуулах цооног байгуулах үйл явц





Зураг 23. Бохир ус цуглуулах цооног, бохир усыг соруулан тээвэрлэн зайлуулах үйл явц



Зураг 24. Ажилчдын бие засах газар




Зураг 25. Мод тарьсан байдал



Зураг 26. Хулхи хунчирын талбай



Зураг 27. Хулхи хунчирын талбайгаас үр түүж байгаа байдал



Зураг 28. Замын тэмдэг тэмдэглэгээ

БОМТ 2025 оны биелэлтийн зорилго, зорилт

“Улиастай-Алтай чиглэлийн авто замын улиастай Цагаанхайрхан хэсгийн 40.9 км хатуу хучилттай авто зам барих” төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний биелэлтийн гол зорилго нь тус зам барилга угсралтын ажил гүйцэтгэн, ашиглалтад оруулах, ашиглах тодорхой үе шатанд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзэн, холбогдох зардлыг бодитоор төлөвлөх, улмаар төсөл хэрэгжүүлэгч энэхүү төлөвлөгөөг дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

БОМТ-ний үндсэн зорилгыг хангахын тулд төсөл хэрэгжүүлэгчийн санхүүгийн чадавхын хүрээнд нийгмийн хариуцлагыг өндөржүүлэхэд чиглэсэн дараах зорилтыг хангана. Үүнд:

1. БОМТ-нд тусгасан ажлын дараалал, түүнийг хийж гүйцэтгэснээр хүрэх үр дүнг нөхөн сэргээлтэд тавих шаардлагын хэмжээнд хүргэх;
2. БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон орон нутгийн оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
3. БОМТ-г зохих ёсоор хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад бэлэн байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

II. СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, биелэлт

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ биелэлт	Биелэлт Зардал
Агаарын чанар		
Замын барилгын ажлын үед агаарт тоосжилт, тээврийн хэрэгслийн утаа, хог хаягдал зэрэг сөрөг нөлөөлөл үүсэж болзошгүй.	Тоосжилт ихсэх үед чийгшүүлэх арга хэмжээг цаг агаарын улирлын байдлыг харгалзан авах	Зам, талбайг услах ажлыг дулааны улиралд өдөр бүр, 9,10 дугаар сард бороо, цас, орчны температураас хамааруулан зөвхөн тоосжилт их байгаа бутлуур, тээвэрлэлтийн замд хийсэн. Зурагт үзүүлэв. 500.000₮
	Зам барих ажлын явцад үүсэх туслах замуудыг урьдчилан нарийн тогтоох, тэмдэг, тэмдэглэгээ тавих	Тэмдэгжүүлэлт хийхээр төлөвлөн, арга хэмжээ авч ажиллан тэмдэг, тэмдэглэгээ байрлуулсан. 500.000₮
	Ажилчдын түр баазаас үүсэх хог хаягдлыг зохих ангиллын дагуу ангилж зохих хаягдлын цэгт хаях, шатаахгүй байх	Ажилчдын түр баазаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах хогийн цэгийг барьж байна. Энгийн хог хаягдал хаях гэрээг Алдархаан сумын ЗДТГ-тай байгуулсан ба гэрээний дагуу төвлөрсөн цэгт хогоо хаяж байна.

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ биелэлт	Биелэлт Зардал
	Дагтаршаагүй замаар явах үедээ машин техникийн хурдыг хязгаарлах	Хурд хязгаарлах арга хэмжээ авч ажиллаа. 100.000₮
	Асфалт завод болон бутлуурын үйлдвэрийн талбай, түхий эдийн материалын чийгшүүлэх	Усалгааг өдөр бүр хийж байгаа ба тухайн өдрийн усны машины ажилласан бүртгэлээр баталгаажна. 200.000₮
	Асфальт завод болон бутлуурын үйлдвэрийн орчмыг тоосжилт үүсгэхээс сэргийлж хайрга дэвсэх	Хийгдээгүй.
Гадаргын болон газар доорх ус		
Бохирдлын эх үүсвэр шатах тослох материал, ахуйн бохир ус болно. Дээрх эх үүсвэрүүд нь гадаргын болон газрын доорх усыг шууд, шууд бусаар бохирдуулах, горимд өөрчлөлт оруулах магадлалтай.	Шатахуун буулгах, цэнэглэх талбайн хөрсийг хатуу хучилттай болгох	Хатуу хучилттай болгосон. 1.000.000₮
	Ахуйн бохир усыг хөрс бохирдуулахааргүй цооногт хуримтлуулан ариун цэврийн байгууллагаас тогтоосон цэгт зайлуулж байх, дахин боловсруулж зам усалгаанд ашиглах технологийг судлах, хэрэглэх	Ахуйн бохир ус хуримтлуулах цооног барьсан ба Бохир ус татан зайлуулах гэрээг “Амь-Ус” ХХК-тай байгуулж цооног дүүрсэн тохиолдол бүрд соруулж зөөвөрлөж байна. 150.000₮
	Ундны ус хадгалах, нөөцлөх, сав бэлдэх	Ахуйн зориулалтаар ус ашиглах гүний худаг гарган шугам татаж ундны ус нөөцлөх савыг байршуулан ашиглаж байна. 1.500.000₮
	Гүний худаг дээр боломжит нөөцийн дүгнэлт гаргуулах	Гүний худаг дээр боломжит нөөцийн дүгнэлт гаргуулахаар аймгийн БОГ-т хүсэлт, материалаа хүргүүлсэн ба тухайн асуудал хариуцсан мэргэжилтнээс зөвлөгөө авч ажиллаж байна.
	Зам барилгын ажлын явцад сайр, жалга, судгийн ус хурах талбайд нефтийн бүтээгдэхүүний бохирдол үүсгэхээс зайлсхийж, нэгдсэн зогсоол байгуулах	Ажлын цаг дуусан үед кемпын хашаанд машин, техникүүдийг нэгдсэн зогсоолд зогсоож байрлуулдаг.
Хөрс болон ургамалан бүрхэвч		
Замын гүүрний барилгын ажлын улмаас газрын гадарга, хөрс эвдрэх, ургамлан бүрхэвч устах хөрс хог хаягдлаар бохирдох	Техник тоног төхөөрөмжийн эд анги, ашигласан тос тосолгооны материалыг нэгдсэн байдлаар зайлуулах	Аюултай хог хаягдал Шилжүүлэх гэрээг “Электрокем монгол” ХХК-тай, Аюултай хог хаягдал хүлээн авч тээвэрлэх гэрээг “Хай би ойл” ХХК-тай байгуулж техник тоног төхөөрөмжийн эд анги, ашигласан тос тосолгооны материалыг нэгдсэн байдлаар

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ биелэлт	Биелэлт Зардал
Шатах тослох материал, техник хэрэгслийн эд ангиар хөрс бохирдох Олон салаа зам үүсэж хөрс, ургамлан бүрхэвч талхлагдах		зайлуулах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна. 1.000.000₮
	Төслийн хүрээнд ашиглагдах техник тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний талбайг засаж тохижуулах	Засварын газар баригдаж байгаа ба 2026 онд бүрэн ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. Одоогоор үйлчилгээ явуулах хэсгийн шалыг хатуу хучилттай болгон засвар хийж байна. Мөн түрээсийн машинууд засвар үйлчилгээ хийх талбай бий болгож хатуу хучилттай болгосон. 1.500.000₮
	Трассын дагуух барилгын ажлын хүрээнд гадаад, дотоод замын сүлжээ байгуулж, замын зорчих хэсгийн өргөнийг тогтоож, хязгаарлалт хийх, тэмдэгжүүлэх арга хэмжээ авах	Тэмдэгжүүлэлт хийхээр төлөвлөн, арга хэмжээ авч ажиллан, тэмдэгжүүлсэн 1.000.000₮
	Асфальтын үйлдвэрийн түүхий эдийн материалын суурийг хатуу хучилттай болгох	Төлөвлөөд бэлтгэл шатанд байгаа 500.000₮
Трассын дагуу өртөж буй Хунчир болон хулих Хонин арц өртөх	Трассын дагуу өртөж буй Хунчир болон хулих Хонин арцыг нүүлгэн шилжүүлэх	Цагаанхайрхан сумын ЗДТГ-тай “Ургамал шилжүүлэх суулгах чиглэлээр хамтран ажиллах гэрээ” байгуулж үйл ажиллагааны зардал шилжүүлсэн. 4.500.000₮
	Хамгаалалтад авах хашаалах, тэмдэг, тэмдэглээ тавих	Энэ жилийн ажлын гүйцэтгэлд трассын дагуу өртөж буй ховор ургамал байгаа хэсэгт хөрс хуулалт, газар хөндөлт хийгдээгүй байна.
	Мэргэжлийн судлаач болон Цагаанхайрхан сум, аймгийн Байгаль орчны газартай хамтран ажиллах	Сумын удирдлага, байгаль хамгаалагч, аймгийн байгаль орчны газрын Биологийн төрөл зүйл хариуцсан мэргэжилтэнтэй мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна.
АМЬТНЫ АЙМАГ		
Амьтад машинд дайруулах, чөлөөтэй нүүдэллэх боломжгүй болох	Зам дагуу мал сүргийн ус уудаг худаг, булаг шандад хүрэх зөрөг зам, дайран өнгөрч байгаа автозамын хэсгүүд дээр жолооч нарт анхааруулсан тэмдэг, түр гарцууд хийж байрлуулах	Тэмдэг тэмдэглэгээ байршуулсан 1.000.000₮

Болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ биелэлт	Биелэлт Зардал
Мал амьтад ухсан нүхэнд унаж бэртэх	Чулуу, элс хайрганы карьерын нуралт гулсалт үүсэж болзошгүй эгц налуу хэсгүүдэд хүн, мал амьтан орохоос хамгаалах хамгаалалтын хайс, тор хийх;	Эрэг нурах аюултай хэсэгт тууз татаж анхааруулсан. 500.000₮
Голын ойр орчим шувууны үүрийг сүйтгэх	Гүүрэн байгууламжийн барих газрын 50-100м орчим газарт шувууны үүр байгааг шалгаж тэмдэглэх	Заагдсан хэмжээнд шувууны үүр хамрагдаагүй болно.

III. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Хэрэгжиж дууссан ажлын нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, биелэлт

Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээлтийн биелэлт
Газар шорооны ажлын үед өртөж эвдэрсэн зам, талбайг цэвэрлэж, засаж тэгшлэх, нөхөн сэргээх	2025 онд зам барилгын ажлын бэлтгэл үе шатны ажил явагдан, хөрс хуулалтын ажил явагдсан. Эвдрэлд өртсөн газрын цэвэрлэж, нөхөн сэргээж ажилласан. Мөн ажилчдын кемпийн хашаанд мод тарьсан.

IV. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө нь газрын тос, уул уурхай, цацраг идэвхт ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөлд өртөн нөхөн сэргэхгүй газарт биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргадаг ба уг төслийн хувьд дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөг боловсруулах шаардлагагүй дэд бүтцийн төсөл болно.

V. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Төсөл хэрэгжүүлэгч компани нь нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээг хариуцан ажиллах үүрэг хүлээдэг бөгөөд тус төслийн хувьд урьдчилсан байдлаар нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ төлөвлөгдөөгүй.	Зам барилгын ажлын явцад нүүлгэн шилжүүлэлт хийгдэж ямар нэгэн асуудал үүсэлгүй ажил хэвийн явагдсан.

VI. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн орчимд түүх, соёлын өв, дурсгалт зүйлс, археологи, палентлогийн олдвор бүхий газар байхгүй тул сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон тул зардал төлөвлөх шаардлагагүй болно. 2025 оны барилга угсралтын ажлын үед түүх соёлын дурсгалт зүйл олдоогүй.	

VII. ОСОЛ ЭРСДЭЛ, ХИМИЙН БОДИСЫН МЕНЕЖМЕНТ, БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжүүлэх явцад гарах эрсдэл нь технологийн үйл ажиллагаанаас үүдэн гарч болзошгүй тул осол, эрсдэлийг урьдчилан тооцох, дотоод хяналтыг байнга тавих, ослын үед яаралтай арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай материал болон авран хамгаалах хэрэгслийн нөөцийг хангаж,

ажиллагсдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгөх, сургалт зохион байгуулан, үйл ажиллагаандаа дотоод хяналт тавин ажилласан.

Арга хэмжээ	Хэрэгжилт
Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	ХХАА-ний дүрмийн чанд сахин ажилласан бөгөөд тогтмол хяналт шалгалт явуулж байсан.
Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Галын аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт 1 удаа явуулсан
Ажилчдын түр баазад үер усны аюул, гал түймрээс урьдчилан сэргийлэх тусгай бүдүүвч схем боловсруулан батлах	ХАБ Үерийн ус орж ирж болзошгүй хэсэгт далан байгуулж ажилласан.
Төслийн томоохон объектын ойролцоо аянга зайлуулагч байрлуулах	Шатахуун түгээх цэгийн орчинд аянга зайлуулагч хийж аймгийн Алтай-Улиастайн ЭХС” ТӨК-ний ажилтнуудаар хүчдэлийг хэмжүүлж аюулгүй байдлыг ханган ажиллаж байна.
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Жолооч нарт Байгаль орчныг хамгаалах талаар нэг удаагийн сургалт орсон. Мөн машин бүрд санамж, анхааруулгын хуудас тарааж байршуулсан. Сумдын удирдлагууд, байгаль хамгаалагч, БОХУБ нартай харилцаа холбоотой ажиллаж байна.
Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах	Гал унтраах багаж хэрэгслээр хангах арга хэмжээг авч ажиллаж байгаа
Асфальт завод болон бутлуурын үйлдвэрийн үйл ажиллагааны үед аюулгүй ажиллагааны дүрэм болон үйлдвэрийн технологийн процессыг горимыг алдагдуулахгүй байх	ХХАА-ний дүрмийн чанд сахин ажилласан бөгөөд тогтмол хяналт шалгалт явуулж байсан.

VIII. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Хог хаягдлын менежментийг зохистой төлөвлөн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх буюу 5Э зарчмыг баримтлан ажиллах	Хог хаягдалыг аль болох эх үүсвэр дээр нь ангиалан ялгах, зориулалтын хогийн сав барих, холбогдох газруудад нь хүлээлгэж өгөх,шилжүүлэх тээвэрлүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна.
Зөөврийн бие засах байгууламж, шингэн хаягдлын цооногийг стандарт шаардлагын дагуу байгуулах, ариун цэврийн бүс тогтоох	Шингэн хаягдлын цооногыг стандарт шаардлагын дагуу байгуулж, бохир ус хадгалах саванд хуримтлуулан гэрээ хийсэн байгууллагаар соруулж зөөвөрлүүлэн ажиллаж байна. Мөн сар бүр тогтмол ариутгал хийж ажиллаа.
Ажлын талбайн хэсгүүд ба түр сууринуудад хатуу хог хаягдлыг ангиалан ялгах зориулалтын зөөврийн савуудтай байх	Кемпийн хашаанд зөөврийн хогийн савууд байрлуулан эх үүсвэрээс гарч буй энгийн хог хаягдлыг түр бөөгнүүлэн хогийн төвлөрсөн цэгрүү шилжүүлж байна.

Арга хэмжээ	Хэрэгжилт
	1.000.000₮
Алдархаан, Цагаанхайрхан сумуудын төрийн захиргаан төв байгууллагатай хог хаягдлын гэрээ байгуулах	Алдархаан сумын ЗДТГ-тай “Хог хаягдал хаях гэрээ” байгуулан төвлөрсөн хогийн цэгрүү шилжүүлж байна.
Хатуу шингэн хог хаягдлыг графикийн дагуу орон нутгаас тогтоосон зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэгт зайлуулах, дарж булшлах	Гэрээний дагуу тогтоосон зөвшөөрөл бүхий нэгдсэн хогийн цэгт зайлуулах ажил хийгдэж байна.
Ажилчдын баазын хатуу суурьтай хогийг цэгийг байгуулах	Барьж байна. 1.500.000₮
Барилгын ажлын явцад гарсан илүүдэл чулуу, шороо болон барилгын ажилчдын суурингийн талбай, түүхий эд материалын агуулах, машин техникийн зогсоолын талбай, хог хаягдлын талбай зэргийг бүрэн цэвэрлэж, хог хаягдлыг зохих газар нь хаях, бэлчээр сайжруулалт хийх	Хог хаягдлын цэвэрлэж гэрээний дагуу Алдархаан сумын төвлөрсөн цэгт хаяж байна.
Авто машин механизмын ашигласан тос, тосолгооны материалыг битүү саванд хуримтлуулан хадгалж дахин боловсруулах үйлдвэрт тушаах	Ашигласан тосыг 200 литрийн пошкинд хийж аюултай хог хаягдал түр хадгалах цэгт хадгалаж байгаа байна. Гэрээний дагуу “Хай би ойл” ХХК-д шилжүүлэхэд бэлтгэж байна.
Авто машин механизмын ашигласан тос, тосолгооны материал, аккумулятор, дугуй зэргийг хадгалах газрын суурыг хатуу хучилттай болгох	Аюултай хог хаягдал түр хадгалах цэгийг хатуу хучилттай болгосон. 1.000.000₮

IX. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, БИЕЛЭЛТ

Арга хэмжээ	Хэрэгжилт
Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль орчны алба болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Аймгийн БОГ, сумын байгаль хамгаалагч, БОХУБ, Сав газрын захиргааны мэргэжилтнүүдтэй харилцаа холбоотой ажиллаж байна.
Ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг системтэй зохион байгуулах	Сургалт зохион байгуулж ажиллаа.
Байгаль орчныг хамгаалах талаар сурталчилгаа анхааруулгын самбар, хуудас гаргах	Байгаль орчныг хамгаалах талаар сургалт сурталчилгааг хийсэн
Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Төлөвлөгөө боловсруулах шатанд байгаа
Трассын дагуу өртөж буй Хунчир болон хулих Хонин арц өртөх хэсэгт барилгын ажил хийхгүй байх	Одоогоор зам барилгын үйл ажиллагаа явагдаагүй байна.
Төслийн хугацаанд байгаль орчныг хариуцсан мэргэжилтэнтэй болох тухайн мэргэжилтэн нь байгаль орчинтой холбоотой асуудал, мэдээлэл, хяналт тавих, бүртгэлжүүлэх	Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна.

Х. БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

10.1. Танилцуулга

“Улиастай-Алтай чиглэлийн авто замын улиастай Цагаанхайрхан хэсгийн 40.9 км хатуу хучилттай авто зам барих” төслийн 2025 оны БОМТ, Хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгаснаар ус, агаар, хөрсөнд судалгаа, шинжилгээ хийж гүйцэтгэв.

10.2. Байгаль орчны хяналтын төлөвлөгөө, шаардлага

Агаар орчны судалгааны дүнг MNS 4858:2016 – Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага, хөрсөн орчны судалгааны дүнг MNS 5850:2008 – Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ, усан орчны судалгааны дүнг MNS 0900-2018 Ундны ус, стандартуудтай харьцуулан дүгнэлт хийж байна.

10.3. Агаар чанарын мониторинг

Агаар орчин:

1. Төслийн хугацаанд газар шорооны ажил хийгдэх, түүхий эд материал тээвэрлэлтийн явцад тоос дэгдэж тодорхой хэмжээнд түр хугацаанд агаарын бохирдол үүсгэнэ. Энэхүү шатанд тоосны дэгдэлтийг багасгах зорилгоор ус цацах арга хэмжээ авч ажилласан.
2. “Улиастай-Алтай чиглэлийн авто замын улиастай Цагаанхайрхан хэсгийн 40.9 км хатуу хучилттай авто зам барих” төслийн 2025 оны агаарын чанарын хяналт шинжилгээний дүнгээр төслийн талбайд Монгол улсын агаарын чанарын стандарт болох MNS 4585:2016 стандартыг давсан агаар дахь бохирдуулагч бодис PM_{2,5}, PM₁₀, төслийн барилгын ажлын үед агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл дунд гэж үзэж байна. Иймд тухай талбайн орчмыг чийгшүүлэх болон тоосжилтыг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байна.
3. Хэмжилтийн үр дүнгээс харахад агаар дахь том ширхэглэгт тоосонцор 3,9-225 мкг/м³-ийн хооронд, нарийн ширхэглэгт тоосонцор 2,8-150,2 мкг/м³-ийн хооронд, нүүрстөрөгчийн дутуу исэл нь 711-750 мкг/м³, Азотын давхар исэл нь 0-0.022 мкг/м³ буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин бага үзүүлэлттэй байна.
4. Орчны дуу шуугианы төвшин төслийн барилгын ажлын өмнөх үед барилга байгууламж барих газруудын орчимд зөвшөөрөгдөх хэмжээнээс их байна. Авто замын дагуу дуу чимээ стандарт хэмжээнээс бага байна.

10.4. Газрын гадарга, хөрсний мониторинг

Хөрсөн орчин:

1. Төслийн талбайд барилгын ажилтай улбаатай хөрсний эвдрэл үүссэн.
2. Машин техникийн хөдөлгөөнийг хязгаарлаж, нэг замаар зорчиж байгаа тул хөрсний эвдрэл үүсэх нь бараг үгүй байна.
3. Хөрс бохирдуулахгүй байх арга хэмжээг байнга авч хэрэгжүүлж байсан.
4. Хөрсний лабораторийн шинжилгээний дүнгээс үзэхэд хөрсний биологийн идэвх, ургамлын өсөлт хөгжилтөд таатай юм. Хөрс 0-30 см үедээ 1.13-1.46 хувийн ялзмагтай байна. 30 см-ээс доош ялзмаг агуулалт эрс буурч байна.
5. Хөрсний үржил шимийн гол үзүүлэлт болох ялзмагийн хэмжээ төслийн талбай түүний орчмын хөрсөнд 1.13-1.46% хооронд хэлбэлзэж байна. Хөрсөнд агуулагдах давсны хэмжээг тодорхойлох ЕС (хөрсний цахилгаан дамжуулах чадвар)-ийн хэмжээ 0.078-0.101 dS/m хооронд хэлбэлзэнэ. Өөрөөр хэлбэл, 1 dS/m-ээс доош агууламжтай хөрсийг давсгүй гэж үзнэ. Урвалын орчин төслийн талбайн хөрсөнд 7.48-7.72 хооронд хэлбэлзэж байна. Нийт талбайн хэмжээгээр авч үзвэл урвалын

орчин дунджаар хэмжээ нь 7.57 буюу хүчтэй шүлтлэг түвшинд байна. Ургамлын хүнс тэжээлд шууд хэрэглэгдэх хөдөлгөөнт фосфорын хэмжээ харьцангуй бага түвшинд буюу 100 гр хөрсөнд 0.9-4.4 мг хооронд хэлбэлзэнэ. Мөн түүнчлэн 100 гр хөрсөнд байх хөдөлгөөнт калийн хэмжээ багавтар түвшинд буюу 23-28 мг-ийн хооронд хэлбэлзэнэ. Ургамлын ургалтад зайлшгүй шаардлагатай дагалдах элемент Са хэмжээ 9-12 мг-экв/100 гр, харин Mg хэмжээ 7-8 мг-экв/100 гр хооронд тус тус хэлбэлзэнэ.

6. Хөрс судлалын лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх 6 төрлийн элементүүд бүх дээжийн хувьд “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019” стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ.
7. “Нарт шуун консалтинг” ХХК-ний итгэмжлэгдсэн лабораторийн задлан шинжилгээний дүнгээр дээрх 4 төрлийн үзүүлэлт бүх дээжний хувьд E.Coli, Salmonella, Cl.perfringens, нянгийн нийт тоо хэмжээ MNS 6341:2012, MNS 5367:2004, стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс бага буюу бохирдол үүсээгүй байгааг илтгэнэ. Гэдэсний савханцарын титр (E.coli) илэрсэн байна.
8. Мөн хөрсний үе давхаргуудад элсний агууламж давамгайлах учраас салхи, усны элэгдэлд өртөх эрсдэл өндөр байдаг бөгөөд цаашид элэгдэл, эвдрэлд орох талбай нэмэгдэх хандлагатай байна.

10.5. Усны мониторинг

Усан орчин:

1. Усны мониторинг судалгааг төслийн талбайн байрлах Богдын гол, Ажилчдын кемп дээр гаргасан гүний худаг нийт 2 цэгээс дээж авч, лабораторийн задлан шинжилгээ хийлгэв.
2. Лабораторийн задлан шинжилгээ нь MNS 4586:1998 стандартын зөвшөөрөгдөх хэмжээнээс 2 элемент давсан байна.
3. Ажилчдын кемп дээр гаргасан гүний худгийн усыг унд ахуйн хэрэглээнд шууд ашиглаж хэрэглэх боломжтой.
4. Төслийн ажилчдын ундны зориулалтаар хэрэглэдэг гүний худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг, маш зөөлөн ус байна. Шинжилсэн химийн үндсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны стандарт MNS 0900:2018” стандартын шаардлага хангаж байна.

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжүүлэхэд гаргасан зардал

Төлөвлөгөөний бүрдэл хэсгүүд	2025 он
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13.950.000
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	-
Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, биелэлт	-
Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээний биелэлт	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, биелэлт	-
Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, биелэлт	-
Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний хэрэгжилт	3.500.000
Удирдлага зохион байгуулалт, оролцогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх арга хэмжээ, биелэлт	-
Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	925.000
Нийт дүн	18.375.000

Хавсралтууд



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-17/1

Захиалагч: “Тэкол” ХХК

Дээж авсан цэг: Завхан аймаг, Алдархаан сум

Сорьц авсан огноо: 2025 оны 10 сар 13 өдөр

Шинжилгээ хийсэн огноо: 10 сарын 17

Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг- экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Бутлуур үйлдвэр											
1	0-30	7.72	0.040	0.096	1.13	1.96	0.33	9	8	1.5	28
Карьерийн шимт хөрс											
2	0-30	7.52	0.042	0.101	1.46	1.60	0.35	11	7	4.4	23
Шимт хөрсний овоолго											
3	0-30	7.48	0.033	0.078	1.37	0.00	0.26	12	7	0.9	26

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Бутлуур үйлдвэр								
1	0-30	1.9	74.9	10.6	7.2	1.6	3.8	12.6
Карьерийн шимт хөрс								
2	0-30	0.9	62.2	18.2	8.7	3.1	6.9	18.7
Шимт хөрсний овоолго								
3	0-30	5.1	68.6	13.4	7.9	1.6	3.4	12.9

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН. IГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019		Анаэробын (Cl.perfringens) MNS 3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Хог хаягдал	7.2*10 ⁵	0.01	2	≥0.1	1

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Кемпийн зогсоол	0-30	66.7	22.5	0.0	18.4	2.5	19.6
Кемп засвар үйлчилгээ	0-30	22.2	12.5	0.0	1.5	1.1	0.8
Бутлуур үйлдвэр	0-30	44.5	7.5	0.0	1.2	1.1	1.2
Хог хаягдал	0-30	33.4	10.0	0.0	0.7	1.9	0.8

Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019

2025 ОНЫ 10 САРЫН 17 1

Элсэрхэг хөрс	60	50	1	100	60	60
Шавранцар хөрс	100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс	150	100	3	300	100	150

**Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжснд хамаарна*

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд
MNS3310:1991, MNS ISO10390, Хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн
Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд атом
шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН: *С.Оюун* Х.УУГАНЦЭЦЭГ, С.НЯМДАШ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ: *Г.Солонго* Г.СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУҮН Консалтинг ХХК



“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-16

Захиалагч: “Тэкол” ХХК

Дээж авсан цэг: Завхан аймаг Алдархаан сум

Сорьц авсан огноо: 2025 оны 10 сар 10 өдөр

Уст цэгийн төрөл: гүний худаг

Харилцах утас:

Аргын стандарт: MNS1097:2023, MNS ISO 7888:1999, MNS ISO 9297:2005

Катион	1 дм ³			Анион	1 дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca ⁺⁺	32.00	1.60	59.68	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	11.00	0.90	33.82	HCO ₃ ⁻	134.00	2.20	82.08
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	17.00	0.48	17.92
K ⁺	0.00	0.00	0.00	SO ₄ ⁻	0.00	0.00	0.00
Na ⁺	4.00	0.17	6.50	NO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Дүн	47.00	2.68	100.00	Дүн	151.00	2.68	100.00

Анион катионуудын нийлбэр:

(Σ_{A+K}) 198 мг/л

HCO₃-ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: 131 мг/л

Физик үзүүлэлтүүд

Өнгө: 0-өнгөгүй

Үнэр: 0-үнэргүй

Булингар: Булингаргүй

Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 87 ppm

Ерөнхий хатуулаг: 2.50 мг-экв/л

/ зөөлөн ус /

Урвалын орчин: pH- 7.83

Цахилгаан дамжуулах чадвар:

ЕС -0.208 ds/m

TDS: 105 ppm

$$M(0.20) = \frac{HCO_3 \ 82 \ [Cl \ 18]}{Ca \ 60 \ Mg \ 34 \ [Na \ 7]}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, I төрлийн нэн цэнгэг буюу ялимгүй эрдэсжилттэй, зөөлөн ус.

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:

С.НЯМДАШ MSc

Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.





“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836

E-mail: nartconsulting@gmail.com

№ 25/10-20

Захиалагч: “Тэкол” ХХК

Дээж авсан цэг: Завхан аймаг Алдархаан сум

Сорьц авсан огноо: 2025 оны 10 сар 13 өдөр

Уст цэгийн төрөл: Богдын гол

Харилцах утас:

1. УСНЫ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж	Усны хүнд металлын агууламж, мг/л					
	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
ус	0.00	0.13	0	0.52	0	0.01
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 4586:1998						
Хүлцэх агууламж	0.01	0.01	0.00	0.01	0.01	0.01

Жич: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн болно

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД: (MNS 0900:2018 MNS ISO 8288:1999,
Атом шингээлтийн спектрометрээр.)

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:

С.НЯМДАШ MSc

Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.



Нарт ШУУН Консалтинг ХХК

Ургамал шилжүүлэн суулгах чиглэлээр хамтран

ажиллах гэрээ

А Тал (Үйлчлүүлэгч): Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэшн групп компаний төлөөний газар
(цаашид "А тал" гэх)

В тал (Гүйцэтгэгч тал):
Монгол улс. Завхан аймгийн Цагаанхайрхан сумын ЗДТГ
(цаашид "В тал" гэх)

1ДҮГЭЭР ЗҮЙЛ Үүнийг харгалзан үзвэл:

1. А талын замын трассын дагуу Алдархаан сумаас-Цагаанхайрхан сум хүртэлх 40км авто зам (цаашид "Төсөл" гэх) барих төсөлийн хүрээнд Монгол Улсын хуулиар хамгаалагдсан хоёр зүйлийн ургамал илэрсэн.

Хунчир, Арц (цаашид "хамгаалагдсан ургамал" гэх);

2. Экологи, байгаль орчныг хамгаалах үүргээ биелүүлэхийн тулд А тал хөрөнгө гаргаж, В тал ургамал шилжүүлэн суулгах ажлыг зохион байгуулна гэдэгт хоёр тал санал нэг байна.

Хэлэлцүүлгийн дүнд дараах тохиролцоонд хүрэв.

1-р зүйл Шилжүүлэн суулгах хамгаалагдсан ургамалын цар хүрээ, тоо хэмжээг тодорхойлоно

1.1 Шилжүүлэн суулгах газар: В тал экологийн хамгаалалтын шаардлага хангасан тохиромжтой талбайг дангаараа шийднэ.

2 дугаар зүйл Хураамж төлөх

2.1 А тал В талд ажилын төлбөрт нийт 4.5 сая төгрөг (4,500,000 төгрөг)-ийг доор дурдсанчлан төлнө.

- Арц мод шилжүүлэн суулгах төлбөр: 1.5 сая төгрөг (1,500,000 төгрөг)

- Хунчир шилжүүлэн суулгах төлбөр: 3 сая төгрөг (3,000,000 төгрөг)

2.2 Төлбөрийн аргууд:

Нэг удаагийн төлбөр: төлбөрийг гэрээнд гарын үсэг зурснаас хойш ажлын 5 хоногийн дотор дуусгана;

3 дугаар зүйл В талын үүрэг хариуцлага

3,1 Хамгаалагдсан ургамалыг шилжүүлэн суулгах мэргэжлийн баг байгуулж, шинжлэх ухааны үндэслэлтэй шилжүүлэн суулгах төлөвлөгөөг (хугацаа, техникийн үзүүлэлтийг оруулан) боловсруулж, ургамал шилжүүлэн суулгах орон нутгийн хуваарийн дагуу 2025 оны 9 дүгээр сард багтаан шилжүүлэн суулгах ажлыг дуусгана.

3,2 Шилжүүлэн суулгах үйл явц нь Монгол Улсын ховордсон ургамал хамгааллын тухай хууль, экологийг хамгаалах олон улсын стандартад нийцэж байгаа эсэхийг баталгаажуулана

3,3 Шилжүүлэн суулгах нь А талын дараагийн барилгын ажилд нөлөөлөхгүй;

4 дүгээр зүйл А талын үүрэг хариуцлага

4,1 Шилжүүлэн суулгах төлбөрийг тохиролцсоны дагуу нэн даруй төлөх;

5 дугаар зүйл Хүлээн авах шалгуур

5,1 Шилжүүлэн суулгаж дууссаны дараа В тал байгаль орчны холбогдох гэрчилгээг хүлээн авч;

Хүлээн авсан гэрчилгээний эх хувийг А талд өгөх шаардлагатай.

6 дугаар зүйл Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээг хоёр хувь (Хятад, Монгол) үйлдсэн бөгөөд хоёр тал гарын үсэг зурж, баталгаажуулсны дараа хүчин төгөлдөр болох бөгөөд хууль эрх зүйн хувьд адил хүчинтэй байна.

А тал (тамга):

Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэшн групп компаний төлөөний газар

Итгэмжлэгдсэн төлөөлөгч

гарын үсэг: 

Огноо: 2025/8/13

В тал (тамга):

Цагаанхайрхан сумын Засаг дарга

гарын үсэг: 

Огноо: 2025.08.15

ХУНЧИР ХАМГААЛАХ ТӨСВИЙ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЙЛАН

2025 оны дугаар сарын 21-ний өдөр

Манай Онц хайрханы шим хоршоо нь Завхан аймгийн Улиастайгаас Говь-алтай аймаг хүртлэх олон улсын чанартай замын транссын дагуух нэн ховор ургамал болох Хунчир ургадаг, хунчирын нөөц бүхий 10-15 га орчим талбайг дайран өнгөрч байгаатай холбогдуулан нөхөн сэргээлэлт хийх зорилгоор үрийг нь түүж авч ажиллаа.

Цагаанхайрхан сумын 2025 оны жилийн эцсийн ИТХ-ын хурлын хуралдаан, Сумын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд Хунчир тариалах 2 га газрыг шийдвэрлүүлэхээр хүсэлтээ хүргээлээд байна. Хунчир тариалах талбайн хашаа, хамгаалалт тариалалтыг хавар 5 нь сард хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэхүү үйл ажиллагаанд нийт 4,5 сая төгрөг төсөвлөгдсөнөөс:

- Цалин хөлс- 3,200,000, /гурван сая хоёр зуун мянган/ төгрөг
- Унаа хоолны зардалд 1,000,000 / нэг сая/ төгрөг
- Хатаалт хадгалалтийн зардал 300,000 /гурван зуун мянган/ төгрөгийг тус тус зарцуулан 2025 оны 08 дугаар сарын 6-9-ний өдрүүдэд түүж, тээвэрлэн нөөцлөөд байна.

ТАЙЛАН ГАРГАСАН: ОНЦ ХАЙРХАНЫ ШИМ ХОРШОО

ДАРГА  ДҮГЭРСҮРЭН

Утас: - 92065523.



“Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэши групп”

Төслийн удирдагч

ХАО ХУНЦҮН

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХҮЛЭЭН АВЧ ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

2025 оны 08-р сарын 22-ны өдөр

№ АХХ-25/39

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 2615134 тоот регистрийн, 90100011063 тоот улсын бүртгэлийн дугаартай “Хай Би Ойл” ХК-г төлөөлж менежер ажилтай Л.Даваагэрэл (цаашид “гүйцэтгэгч” гэх), нөгөө талаас Монгол Улсын хуулийн дагуу байгуулагдан үйл ажиллагаа явуулж байгаа 9947574 тоот регистрийн дугаартай Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэши групп (цаашид “үйлчлүүлэгч” гэх) нар дор дурдсан зүйлийг харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын Иргэний /380-397/ хууль, Хог хаягдлын тухай хуулийн /Дөрөвдүгээр бүлэг, Хоёр дугаар бүлэг 10 дугаар зүйл, Тавдугаар бүлэг/ холбогдох зүйл заалтыг баримтлан энэхүү Аюултай хог хаягдал буюу техникийн ажилласан тос хүлээн авч тээвэрлэх гэрээг байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ,

- 1.1 Энэхүү гэрээгээр “Хай Би Ойл” ХК болон “Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэши групп” ХХК-ийн Засвар үйлчилгээний төв /цаашид ЗҮТ гэх/ гэрээнд заасан хугацаанд машин механизмын, тоног төхөөрөмжийн, хөдөлгүүрийн, гидрийн болон моторын тосыг солих үед гарах техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдал /цаашид “АХХ” гэх/-г хүлээн авах, түүнийг тээвэрлэх болон бусад холбогдох харилцааг зохицуулахад оршино.
- 1.2 Энэхүү гэрээ нь талуудын хооронд хийгдсэн тохиролцоонуудыг агуулж байгаа бөгөөд энэхүү гэрээнд тодорхой байдлаар тусгаж оруулсан заалтуудыг оролцуулахгүйгээр Үйлчилгээтэй холбоотой хэлцэл, мэдэгдэл, аман болон бичгээр хийсэн тохиролцоог энэхүү гэрээ орлож байгаа болно.
- 1.3 Энэхүү гэрээнд өөрөөр заагаагүй бол түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, хоёр тал гарын үсэг зураагүй бол тэдгээрийг хүчин төгөлдөр бус гэж үзнэ.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1 Энэхүү гэрээ нь “Хай Би Ойл” ХК болон “Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэши групп” ХХК-ийн ЗҮТ-ийн төлөөлөлүүд гарын үсэг зурснаар 2026 оны 08 сарын 22-ний өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөнө.
- 2.2 Гэрээнд оролцогч талууд Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээний үүргээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлээгүй гэж үзсэн тохиолдолд гэрээг дуусгавар болгохыг санал болгох эрхтэй.
- 2.3 Гэрээний хугацаа дуусгавар болоход талууд гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар харилцан мэдэгдэж зөвшилцөнө.
- 2.4 Энэхүү гэрээний нөхцөл, болзол, заалтаас тагталзан дуусгавар болгох тухай санал, шалтгааныг талууд зөвхөн албан бичгээр тайлбарлан гаргана.

ГУРАВ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

- 3.1 Талууд бие биенээсээ энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, хэрэгжүүлэхийг шаардах бүрэн эрхтэй.
- 3.2 Талууд аюултай хог хаягдал /цаашид АХХ гэх/-г юүлэх, зөөх, тээвэрлэх, машинд ачиж буулгах зэрэг АХХ-г хөдөлгөх тухай бүрт хариуцлагатай байж, ажлын болон агуулахын талбай, газар шороо, байгаль орчинг бохирдуулахгүй байхад шаардлагатай арга хэмжээг авч хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.3 АХХ буюу техникийн хаягдал тосыг үйлчлүүлэгч нь ямар нэг биет хог /эрэг, боолт, төмөр, чулуу, хуванцар, даавуу, гялгар уут гэх мэт/, механик хольц болон хөргөлтийн шингэн /тосол/, хурдны хайрцагны тос /АКТ/-ны хольцгүйгээр аль болох нэг төрлөөр цуглуулж хүлээлгэн өгөх үүрэгтэй.
- 3.4 АХХ буюу техникийн хаягдал тосыг үйлчлүүлэгч нь гэрээт хугацаандаа тогтмол нийлүүлж байх үүрэгтэй.
- 3.5 Гүйцэтгэгч нь үйлчлүүлэгчийн цуглуулан ангилж буй АХХ буюу техникийн хаягдал тосны чанарын асуудлаар үйлчлүүлэгч талд бичгээр шаардлага хүргүүлэх эрхтэй.
- 3.6 Үйлчлүүлэгч нь АХХ-н тээвэрлэлт, аюулгүй ажиллагаа, ачилтын асуудалд үүсэх эрсдлийг хариуцаж, АХХ үүсгэгчийн талбайгаас өөрийн техникээр тээвэрлэн АХХ-ын цуглуулгын цэг рүү тээвэрлэх үүрэгтэй. Үйлчлүүлэгч нь ачих, тээвэрлэх үедээ хөдөлмөр аюулгүй ажиллагааг сайтар ханган ажиллах ба аюулгүй ажиллагааг хангаагүйгээс үүдэн “Хай Би Ойл” ХК болон бусад гуравдагч этгээдэд хохирол учруулбал бие даан хариуцан барагдуулна.
- 3.7 Энэхүү гэрээний дагуу өгөх шаардлагатай эсхүл өгөхийг зөвшөөрсөн аливаа мэдэгдлийг бичгээр үйлдэх бөгөөд түүнийг биечлэн хүргүүлэх эсхүл доор заасан цахим шуудангийн хаягаар илгээсэн тохиолдолд аливаа мэдэгдлийг хүлээж авснаа талууд бичгээр хариу мэдэгдэх үүрэгтэй.
- 3.8 Энэхүү гэрээ байгуулсантай холбогдон олж авсан талуудтай холбоотой мэдээлэл, баримтын нууцлалыг гэрээ байгуулснаас хойш хоёр тал хугацаагүйгээр чанд хадгалах бөгөөд аль нэг тал нөгөө талд зөвшөөрөл олгосон эсвэл хууль тогтоомжийн дагуу шаардсанаас бусад тохиолдолд аливаа гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй байх, гэрээнд заагаагүй зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.
- 3.9 Үйлчлүүлэгчийн тээвэрлүүлсэн техникийн хаягдал тос буюу аюултай хог хаягдлыг хүлээн авснаар бүх эрсдэл, хариуцлага гүйцэтгэгчид шилжинэ. Хүлээн авсан аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч нь хэрхэн ашиглах, ашигласан нь Үйлчлүүлэгчид үл хамаарна.
- 3.10 Гүйцэтгэгч нь Үйлчлүүлэгчээс хүлээн авсан хаягдал тосыг байгаль орчинд ээлтэйгээр дахин боловсруулна.
- 3.11 Үйлчлүүлэгчийн бэлтгэн нийлүүлсэн АХХ-н хэмжээгээр улиралд тооцоо нийлж, гүйцэтгэгч нь Байгаль Орчин Уур Амьсгалын Өөрчлөлтийн Яаманд мэдээлдэг мэдээ тайландаа тусгаж тайлагнана.

ДӨРӨВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ, ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 4.1 Үйлчлүүлэгч нь өөрийн үүсгэсэн аюултай хог хаягдлыг хүлээн авах дахин боловсруулах, устгахтай холбогдон гарах зардалд шаардагдах үйлчилгээний хөлс төлөх үүрэгтэй бөгөөд энэхүү үйлчилгээний хөлс нь нэг тонн тутам нь 150'000₮ (нэг зүүн тавин мянга) төгрөг байна. /НӨАТ багтсан болно/

- 4.2. Гүйцэтгэгч нь нийлүүлсэн АХХ-ын хэмжээг талуудын хүлээлгэн өгсөн болон хүлээн авсан ажилтны гарын үсгээр баталгаажсан санхүүгийн анхан шатны баримтын бичилтийг үндэслэн тооцоог гаргаж, нэхэмжлэлийг хүргүүлнэ.
- 4.3. Үйлчлүүлэгч нь одоогоор ажил үйлчилгээгээ тогтвортой явуулж эхлээгүй байгаа тул эхний 1 жилийн гэрээний үйлчилгээний хөлс болох **1,500,000₮/нэг сая таван зуун мянган/ төгрөгийг болох Гүйцэтгэгчийн Худалдаа хөгжлийн банкны IBAN дугаар MN040004000405025812** тоот дансанд урьдчилж шилжүүлэн эхний 1 жилийн хугацаанд хог хаягдлын хураамжаас чөлөөлөгдөнө.

ТАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 5.1 Ямар ч тохиолдолд аль нэг тал түүний хяналтаас гарсан аливаа шалтгаан, нөхцөл байдлын улмаас шууд эсхүл шууд бус байдлаар, бүхэлд нь эсхүл хэсэгчлэн энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүй, үүргийн биелэлт нь хойшлогдсон тохиолдолд нөгөө талын өмнө хариуцлага хүлээхгүй.
- 5.2 Тийм шалтгаан, нөхцөл байдалд: гал түймэр, үер, ажил хаялт, үймээн, хорлон сүтгэх ажиллагаа, дэлбэрэлт, цаг уурын сөрөг нөхцөл, зайлсхийх боломжгүй золгүй явдал, ажиллах хүч, материал, тээвэр эсхүл үйлчилгээ олдохгүй байх, давагдашгүй хүчин зүйлс эсхүл дайсагнагч улсын үйл ажиллагаа, нөгөө талын үйлдэл, шүүхийн шийдвэр, тушаал, тогтоол эсхүл Засгийн газрын эрх бүхий байгууллагын журам эсхүл зөвшөөрлийг алдах явдал бөгөөд энэ бүхэн аль ч талын үйлдэлд үндэслэгдээгүй байх ёстой.
- 5.3 Дээрхээс шалтгаалах ажил зогсоолт эсхүл энэ гэрээний дагуу үзүүлэх үйлчилгээний гүйцэтгэл тасалдсаны улмаас цаг хугацааны хувьд хойшлогдох асуудлыг аль болох яаралтай засаж залруулна.

ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ

- 6.1 Энэхүү гэрээг хоёр хувь үйлдэж, талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 6.2 Энэхүү гэрээнд заасан хэлцлүүд хэрэгжсэн эсэхийг үл харгалзан гэрээнд тусгагдсан болон гэрээг бэлтгэх, хэрэгжүүлэх үед гэрээнд оролцогч талуудын зүгээс гарсан аливаа зардлыг талууд өөр өөрсдөө хариуцна.

ДОЛОО. МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ


- 7.1 Талууд харилцагч талынхаа бизнесийн нэр хүндийг хүндэтгэж, тэгш эрхийн зарчимд тулгуурлан ажиллана.
- 7.2 Талууд гэрээний хугацаанд харилцан ашигтай, найрсаг байдлаар хамтран ажиллаж аливаа маргааныг зөвшилцлийн замаар шийдвэрлэх бөгөөд хэрэв тодорхой зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хуулийн дагуу харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭГ БАЙГУУЛСАН:

ТЭЭВЭРЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Хай Би Ойл” ХК-ийн

Менежер Л.Даваагэрэл



/гарын үсэг/

ТЭЭВЭРЛҮҮЛЭГЧ ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ:

“Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэшин групп” ХХК-ийн

Төслийн удирдагч ХАО ХУНШҮН



/гарын үсэг/

ТАЛУУДЫН АЛБАН ЁСНЫ ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот,
Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо,
Сонсголон /18135/ Товчооны зам 59
тоот
Утас: 99904034,80010277
Цахим шуудан:

ganchimeg@hboil.mn

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
2-р хороо, 2-р хороолол, Сөүлийн гудамж, 45/8,
8 давхар
Утас: 80270886
Цахим шуудан:

安卡汗项目
(Ankhan Road Project)

АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ

Дугаар 0000053

Огноо: 2025.08.01

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал
Техникийн хаягдал тосыг тээвэрлэх, цуглуулах,
хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг
(зөвшөөрлийн төрөл)
9010001063 улсын бүртгэлийн дугаартай 2615134
регистрийн дугаартай “Хай би ойл” ХК -д 2025 оны 07 дугаар сарын 31 -ны
өдрөөс 2035 оны 07 дугаар сарын 31 -ны өдөр 10 жилийн хугацаагаар олгов.

Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:

Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа
эрхлэгчийн бүртгэлийн дугаар 000080
Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан
сум, дүүргийн 20 дугаар баг, хорооны товчооны зам гудамж, 59 тоот
(гудамж, байшин/хаалганы дугаар)
Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар
аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20 дугаар
баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд
(газрын нэр/гудамжны нэр, дугаар)

Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.

Зөвшөөрөл олгосон:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

(байгууллагын нэр, албан тушаал)

(гарын үсэг, тамга)

Б.БАТБААТАР

(овог нэр)

==

59643

БАТЛАВ: Чайна жиансу интернэйшнл
Экономик энд техникал корпорэшин групп
төлөөний газар
Төслийн удирдагч
ХАО ХУИШУН



БАТЛАВ: Сайхан улаан оргил ХХК
Гүйцэтгэх захирал
Э.Урантөгс



ХОГ ХАЯГДАЛ “ХАЯГДАЛ ДУГУЙ” ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ ДАХИН
БОЛОВСРУУЛАХ АЖ АХУЙН НЭГЖИД ХАЯГДАЛ ДУГУЙ ШИЛЖҮҮЛЭН ӨГӨХ
ГЭРЭЭ

2025 он 06 сар 20 өдөр

ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

ЭНЭХҮҮ ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ (цаашид “Гэрээ” гэх)

Энэхүү гэрээг нэг талаасХХК РД:
түүнийг төлөөлжалбан тушаалтай овогтой
.....(цаашид “А тал” гэх), Нөгөө талаас Улаанбаатар хот, Налайх Дүүрэг,
3-р хороо, Үйлдвэр технологи Парк өөрийн үйлдвэрийн тоот хаягт орших “Сайхан улаан оргил”
ХХК РД: 5718139 (цаашид “Б тал” гэх) түүнийг төлөөлж захирал Э.УРАНТӨГС нар Монгол
Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн дор дурдсан
нөхцлөөр харилцан тохиролцож байгуулав.

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Гэрээний зорилго

Энэхүү гэрээний зорилго нь хүнд даацын тээврийн хэрэгсэлийн автомашины хаягдал дугуйнуудыг А талын дахивар хадгалах цэгээс авч Б тал өөрийн зардлаар тээвэрлэн шилжүүлэх, А тал нь Б талд тухайн цэгт нэвтрэх, ашиглалтаас гарсан дугуйнуудыг Б талд олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

2. Гэрээний хугацаа

2.1 Гэрээний хугацаа нь гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1 /нэг/ жилийн хугацаатай байх ба талуудыг саналаар 2 хүртэл жилээр сунгах боломжтой.

2.2 Энэхүү гэрээ нь Б тал Хаягдал дугуй дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх тусгай зовшоорол авснаар гэрээний 2.1-д заасан хугацаанд хүчин төгөлдөр хэрэгжих ба А тал нь Б талийг гэрээний хэрэгжилтийг хангах хүртэл хугацаа тогтоож болно.

2.3 Энэхүү гэрээний хаягдал дугуй дахин боловсруулах хөлсийг Талууд дараах байдлаар тохиролцов.

№	Төрөл	Хаягдлын хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн хөлс / тог /	Нийт /мян.тог/
1	11R 12R		Ш	10000	НОАТ
2	14R 16R		Ш	23000	НОАТ

3.Талуудын эрх үүрэг

А талын эрх, үүрэг.

3.1.Зам барилгын ажлын явцад үүссэн хүнд даацын тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан дугуй (цаашид “дугуй” гэх)-г тухай бүр харилцан тохиролцож тогтоосон цаг хугацаандаа ачиж авахыг шаардах эрхтэй.

3.2.Б талаас дугуйг ачих үед мөрдөгдөх ХАБЭА болон түүнтэй холбоотой тээвэр, ажиллах хүчинг өөрөө хариуцахыг шаардах эрхтэй.

3.3.Б талд гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах, гэрээний 2.3 дахь заалтын дагуу дахин боловсруулах зардлыг төлөхийг шаардах эрхтэй.

3.4.Б талд гэрээнд заасан үүргээ биелүүлэх явцдаа энэ гэрээнд зааснаас бусад эд хөрөнгөнд халдахгүй байх, үйл ажиллагаанд саад болохгүй байхыг шаардах эрхтэй.

3.5.Б талын тавьсан санал, гомдлыг хүлээн авч, аль болох нааштай шийдвэрлэх үүрэгтэй.

3.6.Б талтай тохиролцсон цаг хугацаанд дугуйг авах нөхцөлийг бүрдүүлэн оорийн хариуцсан бүсэд саалгүй нэвтрүүлэх, гаргах үүрэгтэй.

Б талын эрх, үүрэг

3.7 Хүнд даацын тээврийн хэрэгслийн ашиглалтын хугацаа дууссан дугуйнууд буюу хог хаягдлыг өөрийн хүн хүч, тоног төхөөрөмжөөр үнэ төлбөргүй тээвэрлэн авна.

Дугуйнуудыг ачих явцдаа А талын талбайн дүрэм журам, ХАБЭА дүрэм журамыг дагаж мөрдөх үүрэгтэй.

3.8.А талтай тохиролцсон хугацаанд А талын дотоод үйл ажиллагаанд оролцохгүйгээр дугуйг ачиж авах мөн гэрээний 2.3 дахь заалтын дагуу дахин боловсруулах зардлыг цаг тухайд нь А талд төлөх

3.9.А талд энэ гэрээнд заасан ажил үүрэгтэй холбоотой санал хүсэлтээ илэрхийлэх, шийдвэрлүүлэх эрхтэй.

3.10.А талын гэрээгээр хүлээсэн бусад үүргээ биелүүлэхийг шаардах эрхтэй.

3.11 Б тал нь байгаль орчинд ээлтэй зохистой аргаар дугуйг дахин боловсруулна. Хэрэв Монгол улсын хууль журмыг зөрчвөл Б тал хуулийн хариуцлага хүлээх бөгөөд А талд хамаагүй болно.

5. Нууц мэдээлэл

5.1. Талуудын үйл ажиллагааны онцлогтой холбоотой аливаа мэдээ, мэдээлэл мон нийтэд нээлттэй болоогүй буюу нийтэд нээлттэй болвол Талуудын ашиг, орлого, нэр хүнд, үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх, өрсөлдөх чадварыг нь бууруулах боломжтой технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног тохоромж, санхүүгийн тайлан, тооцоо, төлөвлөгөө, загварчлал болон ирээдүйн үйл ажиллагааны аливаа төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөтэй холбоотой аливаа мэдээ, мэдээлэл, өгөгдөл нь Нууц мэдээлэл байна.

5.2. Талууд Гэрээний хугацаанд олж мэдсэн Гэрээний 7-д заасан Нууц мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.

6. Үүргээ зөрчих

6.1. Талууд Гэрээнд заасан үүргээ зөрчсөн буюу Нууц мэдээллийг бусад этгээдэд аливаа хэлбэр, аргаар, санаатай болон болгоомжгүй байдлаар ил, нээлттэй болговол зөрчил гаргасны улмаас нөгөө талд учирсан хохирол, гэм хор, олох байсан орлогыг нөхөн төлнө.

7. Эрх үүрэг шилжүүлэх

7.1. Аль ч Тал нь энэхүү Гэрээ эсвэл энэхүү Гэрээний дагуу хүлээсэн өөрийн эрх, үүргээ нөгөө

7.2 Талын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлэхийг хориглоно.

8. Нэмэлт өөрчлөлт

8.1. Энэхүү Гэрээ, түүний хавсралтуудад оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь Талууд харилцан зөвшилцөж бичгээр оруулж, шинэчлэн баталснаар хүчин төгөлдөр болно.

8.2. Хэрэв энэхүү Гэрээний аль нэг заалтыг шүүх буюу эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх боломжгүйд тооцсон тохиолдолд тухайн заалтыг талуудын хүсэл сонирхлыг биелүүлэхийн тулд зөвшөөрөгдөхүйц боломжит хэмжээнд хэрэгжүүлэх ба энэхүү Гэрээний үлдсэн хэсэг нь хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ.

9. Гэрээ цуцлах

9.1. Талуун гэрээ цуцлах талаар саналаа гэрээ цуцлахаас өмнө ажлын 5 хоногийн дотор нөгөө талдаа мэдэгдэнэ.

9.2. А тал дараах тохиолдолд гэрээ цуцлах эрхтэй:

9.2.1. Гэрээний 7-д заасан нууц мэдээллийг задруулахгүй байх үүргийг зөрчсөн;

9.2.2. Нөгөө талын урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь буюу хэсэгчлэн эрх, үүргээ шилжүүлсэн тохиолдолд;

9.2.3. Талууд энэхүү Гэрээнд заасан үүргээ хоёр болон түүнээс дээш удаа зөрчсөн;

9.3. Б тал дараах тохиолдолд гэрээ цуцлах эрхтэй:

9.3.1. Гэрээний 7-д заасан нууц мэдээллийг задруулахгүй байх үүргийг зөрчсөн;

9.3.2. Нөгөө талын урьдчилсан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бүхэлд нь буюу хэсэгчлэн эрх, үүргээ шилжүүлсэн тохиолдолд;

9.3.3. Талууд энэхүү Гэрээнд заасан үүргээ хоёр болон түүнээс дээш удаа зөрчсөн;

10. Гэрээний салшгүй хэсэг

10.1. Энэхүү Гэрээний хавсралтууд, аливаа нэмэлт өөрчлөлт нь энэхүү Гэрээний салшгүй хэсэг болно.

11. Гэрээ хүчин төгөлдөр болох

11.1. Талууд энэхүү Гэрээнд гарын үсэг зурж, тамга дарснаар Гэрээ хүчин төгөлдөр болсон гэж үзнэ.

11.2. Талууд энэхүү Гэрээнд заасан нөхцөл, заалтуудыг хүлээн зөвшөөрч буйгаа нотлон гарын үсэг зурж баталгаажуулав.

А ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ

Чайна жиансу интернэйшнл
экономик энд техникал корпорэши
групп төлөөний газар


(гарын үсэг, тамга)
Төслийн удирдагч

ХАО ХУИШУН

Утас: 80368054

Б ТАЛЫГ ТӨЛӨӨЛЖ

Сайхан улаан оргил

ХХК

Э.УРАНТОГ


(гарын үсэг, тамга)
УЛААНБААТАР ХОТ

САЙХАН УЛААН ОРГИЛ

ХХК ЗАХИРАЛ

Утас: 99733351

БАТЛАВ:



“ЧАЙНА ЖИАНСУ
ИНТЕРНЭЙШНЛ ЭКОНОМИК
ЭНД ТЕХНИКАЛ КОРПОРЕШН
ГРУПП” КОМПАНИЙ ТӨЛӨӨНИЙ
ГАЗРЫН ТӨСЛИЙН УДИРДАГЧ
HAO HONGXUN

ХОГ ХАЯГДАЛ ХАЯХ ГЭРЭЭ

2025 оны 09 сарын
Алдархаан
15-ны өдөр

№ ____

Нэг талаас “Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэшн групп” компаний төлөөний газар РД:9947574 /цаашид “захиалагч” гэх/

Нөгөө талаас: Алдархаан сумын Засаг даргын тамгын газар /цаашид гүйцэтгэгч” гэх / түүнийг төлөөлж Байгаль хамгаалагч Д.Ганзориг нар Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/433 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага” зэргийг үндэслэн энэхүү гэргээг байгуулав.

Нэг. Үндсэн нөхцөл

1.1 Захиалагч тал нь түр кемпээс гарах ахуйн хог хаягдлыг зориулалтын автомашинаар тээвэрлэн Алдархаан сумын төвлөрсөн хогийн цэгт хаях, Алдархаан сумын ИТХ-ын 2022 оны 14 дүгээр тогоолын хавсралтаар батлагдсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хувь, хэмжээ”-нд заасан төлбөрийг хугацаанд нь төлөх санхүүгийн харилцааг зохицуулна.

Хоёр. Төлбөр, тооцоо хийх журам

2.1 Нэг сарын хог хаягдалын үнэлгээ: 200 000 /Хоёр зуун мянга /төгрөг байна.

2.2 Зориулалтын цэгт хог хаягдал хаях үеийн нийт тонн, хэмжээний төлбөрийг сар бүрийн 10-ны өдрөөр тооцоо нийлж, Алдархаан сумын Татварын байцаагчийн үүсгэсэн нэхэмжлэлийн дагуу шилжүүлнэ.

2.3 “Хог хаягдлын тухай” хууль, бусад эрх зүйн актын өөрчлөлт, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч үнэ тарифт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулна.

Гурав. Гэрээний үйлчлэх хугацаа

- 3.1 Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож тогтоов.
- 3.2 Гэрээ үйлчилж эхлэх хугацаа: 2025 оны 06 дугаар сарын 01 -ний өдөр байна.
- 3.3 Гэрээний дуусах хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл байна.

Дөрөв. Талуудын эрх, үүрэг

- 4.1 Захиалагч тал нь хог хаягдалыг зориулалтын машинаар ачиж, тээвэрлэх
- 4.2 Захиалагч тал нь хог хаягдал тээвэрлүүлсэн төлбөрөө энэ гэрээний 2.2-т заасны дагуу хугацаанд нь бүрэн төлнө.
- 4.4 Захиалагч тал нь тухайн хогийн цэгт хяналт тавьж буй ажилтнуудын зааврын дагуу хог хаягдалаа буулгана.
- 4.5 Захиалагч тал нь Тэсэрч дэлбэрэх аюултай хог хаягдал болон галтай хог хаягдал ачуулахгүй байх үүрэгтэй.
- 4.8 Талууд өөр өөрсдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилга, холбогдох журмыг чанд мөрдөн ажиллана.
- 4.9 Гүйцэтгэгч тал нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө нэхэмжлэх, шаардан авах эрхтэй.

Тав. Талуудын хүлээх хариуцлага

- 5.1 Талууд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, энэхүү гэрээг сахин биелүүлж ажиллана.
- 5.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

Зургаа. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

- 6.1 Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахаар бол харилцан зөвшилцсөний үндсэн дээр нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн эрх бүхий этгээдийн гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулна.
- 6.2 Гэрээний хугацааг сунгах болон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай саналаа аль нэг тал энэ гэрээний хугацаа дуусахаас нэгээс доошгүй өдрийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэх ба уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор нөгөө тал хариу мэдэгдэнэ.
- 6.3 Гэрээний сунгалт, нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээний салшгүй хэсэг байна.

Долоо. Гэрээ цуцлах журам

- 7.1 Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно.

7.2 Талуудын аль нэг нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө талын санаачилгаар гэрээг цуцалж болно.

7.3 Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан

үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж

болно.

7.4 Хэрэв аль нэг тал гэрээг цуцлах саналтай бол нөгөө талдаа 1 сарын өмнө албан бичгээр мэдэгдэж, гэрээ цуцалсан тухай акт үйлдэн үйлчилгээ, төлбөр тооцоог дуусгавар болгоно.

Найм. Давагдашгүй хүчин зүйл

8.1 Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно.

8.2 Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хойшлуулж болно.

8.3 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

Ес. Маргаан шийдвэрлэх

9.1 Энэхүү гэрээнд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

9.2 Энэхүү гэрээний хэрэгжилтийн явцад талуудын хооронд гарах аливаа асуудлыг албан бичгээр мэдэгдэнэ.

9.3 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар үүссэн маргааныг гэрээний үндсэн нөхцөл, агуулгад нийцүүлж талууд зөвшилцөх замаар шийдвэрлэх ба зөвшилцөөнд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван. Бусад заалт


10.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусгавар болсноор гэрээ дуусгавар болно.


10.2 Гэрээг шинэчлэх, сунгах асуудлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

10.3 Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж талууд тус бүр нэг, нэг хувийг хадгалах ба гэрээний хувь тус бүр хууль зүйн хувьд адил хүчинтэй байна.

10.4 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Гүйцэтгэчийг төлөөлж:
Алдархаан сумын Байгаль
хамгаалагч

/гарын үсэг, тамга/ С.Ганзориг
Утас: 89468575

Захиалагч: "Чайна жиансу
интернэйшнл экономик энд
техникал корпорэшн групп"
компаний төлөөний газар Төслийн
удирдагч 
/гарын үсэг, тамга/
Утас: 99015093



АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ШИЛЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

2024 оны 08-р сарын 26-ны өдөр

№ 8-АШГ-011/25

Улаанбаатар хот

Энэхүү “Аюултай хог хаягдал шилжүүлэх гэрээ” /Цаашид “Гэрээ” гэх/-г,

Нэг талаас Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, Ханну төв, 500 тоот хаягт байрлах, 6352901 тоот регистрийн дугаартай “ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК, /Цаашид “Гүйцэтгэгч” гэх/ түүнийг төлөөлж Гүйцэтгэх Ө.Одонсүрэн,

Нөгөө талаас Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, Сөүлийн гудамж, 45/8, 8 давхар хаягт байрлах, “Чайна жиансу интернэйшнл экономик энд техникал корпорэшин групп” ХХК (РД:9947574), (цаашид “Захиалагч” гэх) /Цаашид хамтад нь “Талууд” гэх/

Монгол улсын “Иргэний хууль”, “Хог хаягдлын тухай хууль”, Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам” болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тээврийн хэрэгслийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ийн зүйл, заалтыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү гэрээгээр захиалагч нь “аюултай хог хаягдал” болох “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г дахин боловсруулж, устгуулах зорилгоор гүйцэтгэгчид шилжүүлэх, аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс төлөх, гүйцэтгэгч холбогдох хууль тогтоомж, журмын дагуу тээвэрлэж, өөрийн үйлдвэрт дахин боловсруулж, устгалд оруулахтай холбоотой талуудын хоорондын харилцаа болон эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг зохицуулна.
- 1.2. Энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй бусад харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Хог хаягдлын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журамд зааснаар зохицуулна.
- 1.3. Талууд гэрээний хугацаанд “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэх бүртгээ БОАЖСайдын 2018 оны 2-р сарын 2-ны өдрийн А/21 тоот тушаалын 1-р хавсралтад заасан маягтын дагуу “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг” /Хавсралт-1/-ийг үйлдэх бөгөөд энэхүү дагалдах бичиг нь гэрээний салшгүй хэсэг байна.



Хоёр. Гэрээний хүрээнд хамтран ажиллах нөхцөл

- 2.1. Гүйцэтгэгч нь захиалагчийн ажилтнуудыг “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г эх үүсвэр дээр түр хадгалахтай холбогдох аюулгүй ажиллагаа, хар тугалгын батарейг бусад төрлийн батарейнаас таньж мэдэх аргачлал зэрэг сэдвээр үнэ төлбөргүй зааж сургаж, гарын авлагаар хангаж болно.
- 2.2. Гүйцэтгэгч нь “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г захиалагчаас хүлээн авахдаа зөвхөн хар тугалгын батарей эсэх, батарейнаас өөр төрлийн эд зүйлс байгаа эсэхийг шалгаж, өөрийн зориулалтын тээврийн хэрэгсэлд жинлэн хүлээн авч, тээвэрлэнэ.
- 2.3. Захиалагч хүссэн нөхцөлд гүйцэтгэгчийн зүгээс “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г зориулалтын хадгалах саваар хангаж болно.
- 2.4. Захиалагч нь өөрт цугларсан батарейны мэдээллийг тухай бүр гүйцэтгэгчид мэдээлж, гэрээний хүрээнд батарейг шилжүүлэх захиалга тухай бүр огч ажиллана.


Гурав. Талуудын эрх, үүрэг

- 3.1. Захиалагч дор дурдсан эрхтэй байна. Үүнд:
 - 3.1.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, зохих ёсоор, бүрэн гүйцэтгэхийг гүйцэтгэгчээс шаардах;
 - 3.1.2. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г тээвэрлэх, хадгалах болон дахин боловсруулж, устгахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу ажиллахын гүйцэтгэгчээс шаардах;
 - 3.1.3. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэн өгөхдөө жинлэх үед хамт байж, хяналт тавих;
 - 3.1.4. Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7.а дахь заалтад заасан маягтын дагуу “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-ийг гүйцэтгэгчээс шаардах;
 - 3.1.5. Хууль болон гэрээнд заасан бусад эрх;
- 3.2. Захиалагч дор дурдсан үүрэгтэй байна. Үүнд:
 - 3.2.1. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г Хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дагуу савлах;
 - 3.2.2. Үүссэн “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г өөрийн салбар нэгжүүдээс нэг цэгт цуглуулан, Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан дагуу эх үүсвэр дээр түр хадгалах;
 - 3.2.3. Захиалагч нь зөвхөн “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г гүйцэтгэгчид шилжүүлэн өгөх;
 - 3.2.4. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г хүлээлгэн өгөхдөө “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-т өөрт холбогдох хэсгийг үнэн зөв бөглөх;
 - 3.2.5. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г гүйцэтгэгчид шилжүүлэх хүртэл түүний аюулгүй байдлыг хадгалж, хамгаалж, түүнээс үүсэх аливаа эрсдэлийг бүрэн хариуцах;
 - 3.2.6. Шилжүүлэн өгсөн “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-ны тээвэрлэлт болон устгуулсан үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулах;

- 3.2.7. “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэх захиалга өгсөн үед тээврийн хэрэгсэл очиход бэлэн байх, хариуцсан ажилтныг аюултай хог хаягдлыг ачих цэгт байлгаж, ажилтанд хяналт тавих;
- 3.2.8. Хууль болон гэрээнд заасан бусад үүрэг;
- 3.3. Гүйцэтгэгч нь дор дурдсан эрхтэй байна. Үүнд:
- 3.3.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар, зохих ёсоор, бүрэн гүйцэтгэхийг захиалагчаас шаардах;
- 3.3.2 Захиалагчаас зөвхөн “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэн авах;
- 3.3.3 Ашиглалтаас гарсан хар тугалгын батарейг шилжүүлэн авч, тээвэрлэх, дахин боловсруулах үйлчилгээний хөлсийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг шаардах;
- 3.3.4. Шилжүүлж буй “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей” нь хог хаягдлын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасан дагуу савлагдсан байхыг захиалагчаас шаардах;
- 3.3.5 Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7.а дахь заалтад заасан маягтын дагуу дагалдах бичгийг захиалагчаас шаардах;
- 3.3. Хууль болон гэрээнд заасан бусад эрх;
- 3.4. Гүйцэтгэгч нь дор дурдсан үүрэгтэй байна. Үүнд:
- 3.4.1 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г зориулалтын тээврийн хэрэгсэлд ачиж хүлээн авах;
- 3.4.2 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэн авахдаа “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг”-ны өөрт холбогдох хэсгийг үнэн зөв бөглөх;
- 3.4.3 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г шилжүүлэн авснаас хойшхи түүний хадгалалт, тээвэрлэлт, дахин боловсруулалт, устгалыг бүрэн хариуцах;
- 3.4.4 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г тээвэрлэх тээврийн хэрэгслийг ажилд бэлэн байлгаж, гэрээнд заасан дагуу саадгүй тээвэрлэх;
- 3.4.5 Аюултай хог хаягдлыг хүлээн авах, тээвэрлэх явцад хууль, журам, стандарт шаардлагад заасны дагуу ажиллах, тээврийн хэрэгсэлийн аюулгүй байдал, ажиллагсдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
- 3.4.6 Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас үүдэн захиалагч болон гүйцэтгэгчийн ажилтан, бусад этгээд бэртэж гэмтсэн, өртсөн, хордсоноос үүдэн гарах хохиролыг гүйцэтгэгч бүрэн хариуцах;
- 3.4.7 “Ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г стандартын шаардлага хангасан үйлдвэрт дахин боловсруулж, устгалд оруулах;
- 3.4.8 Хууль болон энэхүү гэрээнд заасан бусад үүрэг;

Дөрөв. Төлбөр тооцоох

- 4.1. Аюултай хог хаягдлын үйлчилгээний хөлс буюу “ашиглалтаас гарсан хар тугалгын батарей”-г утсгах үйлчилгээний хөлс нь 1 тонн тутамд 1,650,000 төгрөг (Нэг сая зургаан зуун тавин мянга) /НӨАТ орсон/ төгрөг байх бөгөөд үүнд Улаанбаатар хот доторх тээвэрлэлтийн хөлс орсон болно.
- 4.2. Аюултай хог хаягдлыг Улаанбаатар хотоос бусад нутаг дэвсгэрээс тээвэрлэх тохиолдолд талууд тээврийн зардлыг харилцан тохиролцоно.



- 4.3. Аюултай хог хаягдлыг гүйцэтгэгч тээвэрлэлт хийн, дахин боловсруулах үйлдвэртээ хүлээн авч, жинлэлт хийх үед аюултай хог хаягдлыг ачих үеийн жингээс зөрүүтэй гарсан тохиолдолд зөрүү дүнгээр захиалагч талаас нэхэмжлэнэ.
- 4.4. Гэрээний төлбөрийг аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгч, “Аюултай хог хаягдлын дагалдах бичиг” үйлдсэнээс хойш ажлын 1 хоногийн дотор “Электрокем Монгол” ХХК-ийн Голомт банк дахь 8125102557 тоот дансанд төлнө.

Тав. Хариуцлага, маргаан шийдвэрлэх журам

- 5.1. Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн эсхүл үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас нөгөө талдаа учирсан аливаа хохирлыг холбогдох нотлох баримтад үндэслэн бүрэн хариуцаж нөхөн төлнө.
- 5.2. Захиалагчийн шилжүүлсэн гэрээний зүйлд эд хөрөнгийн болон эрхийн доголдол үүссэн нөхцөлд захиалагч нь уг доголдлыг үл маргах журмаар арилгах бөгөөд ийнхүү арилгаагүй нөхцөлд гүйцэтгэгчид хохирол учирбал нөхөн төлөх үүргийг хүлээнэ.
- 5.3. Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой гарсан аливаа санал зөрөлдөөн, маргаантай асуудлыг талууд эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэхийг чармайлх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй нөхцөлд Монгол Улсын хуульд заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Зургаа. Давагдашгүй хүчин зүйл

- 6.1. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн самуун, эмх замбараагүй байдал, ажил хаялт, эрчим хүчний тасалдал, эсэргүүцлийн хөдөлгөөн, гоц халдварт өвчин, дайн, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорно, цээр, сүлжээний хэвийн ажиллагааны горимоос хэтэрсэн гэнэтийн огцом ачаалал зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах, тэдгээрийн хяналтаас гадуур, урьдчилж тооцох болон даван туулах боломжгүй шалтгаануудыг ойлгоно.
- 6.2. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нэн даруй нөгөө талдаа мэдэгдэнэ. Энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно.
- 6.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдал үүссэн тухай тодорхойлолтыг холбогдох эрх бүхий байгууллагаас гаргуулж авна. Энэ тохиолдолд талууд харилцан тохиролцож асуудлыг шийдвэрлэнэ.
- 6.4. Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээний үүргээ биелүүлээгүй, эсвэл зохих ёсоор биелүүлээгүй тал нь энэ тухайгаа нотолсон тохиолдолд хариуцлагаас чөлөөлөгдөнө.

Долоо. Мэдээ, мэдээллийн нууцлалыг хадгалах

- 7.1. Талууд энэхүү гэрээг байгуулсантай холбоотой болон гэрээг хэрэгжүүлэх явцад шууд болон шууд бусаар олж мэдсэн байгууллагын болон ажилтны хувийн нууцад хамааралтай (техник, технологи, санхүү, бизнес, гэрээ хэлцэл, хувь хүний эрүүл мэнд гэх мэт) аливаа мэдээ, мэдээллийг бусдад бичгэн, аман болон бусад хэлбэрээр задруулахгүй байх үүргийг хугацаагүй хүлээнэ.

- 7.2. Энэхүү гэрээний 7.1-д заасан нөхцөлийг зөрчсөн тал үүнтэй холбоотойгоор үүсэх аливаа үр дагавар, хохирлыг хуулийн дагуу арилгах үүрэг хүлээнэ.

Найм. Гэрээ цуцлах, дуусгавар болох

- 8.1. Талууд харилцан тохиролцсоноор гэрээг цуцалж болно. Гэрээг цуцлах тохиолдолд нөгөө талдаа хуанлийн 15-аас доошгүй хоногийн өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдэлд гэрээг цуцлах үндэслэл, цуцлах огноог тодорхой дурдсан байна.
- 8.2. Гэрээ дараах үндэслэлээр хугацаанаас өмнө цуцлагдана. Үүнд:
- 8.2.1 Аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ хоёр болон түүнээс дээш удаа биелүүлээгүй бөгөөд энэ талаар нөгөө талд бичгээр мэдэгдэл, шаардлага хүргүүлсэн боловч биелүүлээгүй;
- 8.2.2 Талууд оролцогч талын нэр хүндэд ноцтой хохирол учруулсан;
- 8.3. Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 8.3.1 Гэрээний хугацаа дуусаж, гэрээний биелэлтийг дүгнэснээр;
- 8.3.2 Талууд харилцан тохиролцсоноор;

Ес. Гэрээний баталгаа

- 9.1 Энэхүү гэрээний үндсэн эхийг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.
- 9.2 Энэхүү гэрээг талууд харилцан тохиролцож цуцлах өдөр хүртэлх хугацаагаар байгуулав.
- 9.3 Энэхүү гэрээ нь талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга дарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээний хугацаа дуусах хүртэл хүчинтэй үйлчилнэ.
- 9.4 Талууд харилцан тохиролцвол гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 9.5 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах санал, хүсэлтийг бичгээр үйлдэж 15-аас доошгүй хуанлийн хоногийн өмнө нөгөө талдаа гэрээнд заасан хаягаар, баталгаат шуудангаар эсвэл биечлэн хүргүүлнэ.
- 9.6 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болно.
- 9.7 Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэх, мэргэжлийн туршлагатай ажилтан, зориулалтын тээврийн хэрэгсэлтэй, ажил гүйцэтгэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн холбогдох хууль журмын дагуу шударгаар авсан бөгөөд тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаагүй болохыг үүгээр баталж байна.

10. Талуудын мэдээлэл

- 10.1 Гүйцэтгэгчийн албан ёсны мэдээлэл.

Компанийн нэр	“ЭЛЕКТРОКЕМ МОНГОЛ” ХХК
Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2 дугаар хороо, Ханну төв, 500
Харилцах утас	95877888, 77229999
И-мэйл хаяг	contact@electrochem.mn , electrochemmongolia@gmail.com

Холбогдох төлөөлөгч	Менежер П.Сангижав
---------------------	--------------------

10.2 Захиалагчийн албан ёсны мэдээлэл.

Компанийн нэр	“Чайна жиапсу интернэйшл экономик энд техникал корпорэйшн групп” төлөөний газар”
Хаяг	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, 2-р хороолол, Сөүлийн гудамж, 45/8, 8 давхар
Харилцах утас	80270886
И-мэйл хаяг	
Холбогдох төлөөлөгч	

Гэрээг байгуулсан:

Гүйцэтгэгчийг төлөөлж:

“Электрокем Монгол” ХХК-ийн
Менежер

П.Сангижав -

М.Н. 8

Захиалагчийг төлөөлж:

“Чайна жиапсу интернэйшл экономик энд техникал корпорэйшн групп” төлөөний газар”
Төслийн удирдагч





БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМ
**ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГАА**

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/К/В

Улиастай

Ус ашиглах зөвшөөрөл
олгох тухай

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11 дэх заалт, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн Е-2508-000263 тоот ус ашиглуулах дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улиастай-Цагаанхайрхан чиглэлийн 40.1км хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжүүлэгч “Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компани”-д 2025 онд далангийн ул хөрс нягтруулахад 9,300.0м³/жил, далангийн дүүргэлтийн ажилд 15,120.0м³/жил, төмөр бетон гүүр болон хоолойн цутгалт 4,200.0м³/жил, зам талбайн усалгаанд 2,000.0м³/жил, ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд 1,390.2м³/жил ус ашиглахыг зөвшөөрсүгэй.

2. Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компанитай ус ашиглах гэрээ байгуулахыг ахлах мэргэжилтэн /Т.Даваажаргал/-д даалгасугай.

3. Дараах арга хэмжээг авч ажиллахыг ус ашиглагч Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компаний төслийн удирдагч /Хао Хоншун/-д үүрэг болгосугай.

3.1 Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуучлалын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015 оны А-230/127 хамтарсан тушаалаар батлагдсан “Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангах;

3.2 Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны А-156 дугаар тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам”-ын хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.3 Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашиглахгүй байх, ашигласан тохиолдолд усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;

3.4 Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийг хэрэгжүүлж, ус ашиглалтын тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнах;

ДАРГА



Э.ЗОЛ-ОД

D:\doc\Tushaal\2025.docx

БАТЛАВ

ХЯРГАС НУУР-ЗАВХАН ГОЛЫН САВ
ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГА
Э.ЗОЛ-ОД

ТТБ5903 3498271

БАТЛАВ.

“ЧАЙНА
ИНТЕРНЭЙШНЛ ЭКОНОМИК
ЭНД ТЕХНИКАЛ КООПЕРЭЙШН
ГРУПП КОМПАНИЙН
ТӨСЛИЙН УДИРДАГЧ

ХАО ХОНШУН
(China Tsaganhaihan Road Project)

УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 09 дүгээр
сарын 29-ны өдөр

Дугаар 07

Завхан аймаг, Улиастай сум

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6, 28.11, 29.1-д -д заасны дагуу “Монгол улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” Усны газрын 2025 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн Е-2508-000263 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Хяргас нуур-Завхан голын сав газрын захиргааны даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/26 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж: Хяргас нуур – Завхан голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн Тогтохсүрэн овогтой Даваажаргал

Ус ашиглагчийг төлөөлж: Завхан аймгийн Алдархаан сумын төвөөс зүүн урагш 5 км, Улиастай хотоос баруун зүгт 25 км, Улаанбаатар хотоос 1025 км зайтай оршино. 9947574 регистрийн дугаартай “Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компани” –ийн Ерөнхий инженер Ду Ганглин нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Ажиллагсдын унд ахуй болон үйлдвэрлэлийн технологийн хэрэгцээнд

2.2. Ашиглах усны хэмжээ: Нийт 32,010.20 м³/жил

2.2.1 Далангийн ул хөрс нягтруулахад 9,300.0м³

2.2.2 Зам талбайн усалгаа 2,000.0м³

2.2.3 Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах 1,390.2м³

2.2.4 Далангийн дүүргэлтийн ажилд 1,5120.0 м³

2.2.5 Төмөр бетон гүүр болон хоолойн цутгалт 4,200.0 м³

“Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компани”-ийн Улиастай-Алтай чиглэл, Улиастай-Цагаанхайрхан хэсгийн 40.1км хатуу хучилттай авто замын ажилд 2025 онд ашиглах усыг гадаргын болон газрын доорх өрөмдмөл худгаас авч ашиглана.

№	Худгийн нэр	Х	У	Худгийн гүн, м	Ундарга л/с
1	Худаг /Буурлын цагаан толгой/	96° 33'58.05"	47° 37' 22.9"	36	2
2	Усны эх үүсвэр 1	96° 35'10.31"	47° 40'28.16"	Завхан аймгийн Алдархаан сум болон Цагаанхайрхан сумын нутгаар дамнан урсах Богдын гол, Яруугийн гол, Ширээгийн голоос хангана. Олон жилийн дундаж урсац 6.6л/с	
3	Усны эх үүсвэр 2	96° 36'39.10"	47° 39'32.86"		
4	Усны эх үүсвэр 3	96° 35'48.20"	47° 38'30.87"		
5	Усны эх үүсвэр 4	96° 35'57.40"	47° 37'35.55"		
6	Усны эх үүсвэр 5	96° 32'49.37"	47° 36'13.84"		
7	Усны эх үүсвэр 6	96° 31'4.01"	47° 35'15.45"		
8	Усны эх үүсвэр 7	96° 30'40.55"	47° 33'36.88"		

2.3. Усны чанар, найрлага:

Уурхайн үйлдвэрлэлийн талбайн ашиглалтын худаг болон голын усны чанарын шинжилгээг улирал бүр шинжлүүлж шинжилгээний дүнг манай сав газрын захиргаанд ирүүлэх

2.4. Усны эх үүсвэрийн:

Байршил: Завхан аймгийн Алдархаан сум Мандаат баг Буурлын цагаан толгой нийт гүний 1ш худаг ашиглана.

Барилга байгууламж: Өрөмдмөл худаг

Тоног төхөөрөмжийн нэр, марк : **Худаг /Буурлын цагаан толгой/**

Гадаргын усыг Завхан аймгийн Алдархаан сум болон Цагаанхайрхан сумын нутгаар дамнан урсах Богдын гол, Яруугийн гол, Ширээгийн голоос хангана.

2.5. Хаягдал усны:

Хэмжээ: Унд ахуйн хэрэгцээнд нормоор тооцоход жилд 1390.2м³ ус хэрэглэж, хэрэглээнээс гарах бохир усыг хөрсөнд нэвчүүлнэ.

Стандартын шаардлага: Хаягдал усыг “Амь-Ус” ХХК-тай 2025 оны 07 сарын 07-ны өдрийн бохир ус татан зайлуулах гэрээний дагуу соруулж төв цэвэрлэх байгууламжид нийлүүлнэ.

2.6 Улирал бүр хоёроос доошгүй удаа хаягдал усны холимог сорьц авч, байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариуг улирал бүрийн сүүлийн сарын 15-ны дотор сав газарт ирүүлэх;

2.7. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос сэргийлэх арга хэмжээ, түүнд зарцуулах хөрөнгийн хэмжээ:

- ✓ Унд-ахуйн усны эх үүсвэрт ариун цэврийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж хайс хамгаалалт хийх, ус тээвэрлэхэд зориулалтын машин, ус хадгалах ган сав ашиглах;
- ✓ Тосгон болон барилгын ажлын технологийн хэрэгцээний үед гарах ахуйн бохир усыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх, бохир усны цэвэршилтийн зэргийг хянах зорилгоор усанд хими, бактериологийн шинжилгээг тогтмол хийж байх;
- ✓ Байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор орчны хяналт шинжилгээ хийлгэх арга хэмжээ авч, усны бохирдол, усны нөөцийн байдалд хяналт тавьж ажиллах /улирал бүр/;



- ✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт заагдсан арга хэмжээг тухайн оны онцлог байдалд тохируулан нарийвчлан төлөвлөн хэрэгжүүлэх;
- ✓ Сав газрын захиргаа болон Алдархаан сумын байгаль хамгаалагч, БОХУ-н байцаагч, компанийн мэргэжилтнүүд нарыг байлцуулан цэвэр усны тоолуурын заалтыг 12-р сарын 10-ны байдлаар дуусгавар болгон баталгаажуулж, дараа оны 1-р сарын 1-с хойшхи заалтыг тайлант оны ус ашиглалтын мэдээ тайланд оруулж байх
- ✓ Ашиглалтын худаг болон Богд, Яруу, Ширээгийн голоос авч буй усыг бүртгэлжүүлж бүртгэлийн дэвтэрийг хөтөлж, баталгаажуулан тайлагнах;
- ✓ Ашиглалтын худгуудын тоолуурын бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж, сар бүр тухайн сумын Байгаль хамгаалагч, БОХУБайцаагч нараар тоолуурын заалтын бичилт хийж акт үйлдэж зургаар баталгаажуулах.
- ✓ Ус ашиглалтын тайлан мэдээг улирал бүр ирүүлэх, мөн жилийн эцсийн тайланг 12-р сарын 15-ны дотор ирүүлж гэрээг дүгнүүлэх;

2.8. Усны тоолуурын:

Төрөл, нэр, дугаар:	Худаг /Буурлын цагаан толгой/
Тоолуурын дугаар:	202400276
Загвар:	LXSG
Тоолуурын тоо:	1
Суурилуулсан байгууллага, огноо:	2025.08.06 “Чайна Жиангсу Интернэйшнл Экономик энд Техникал Кооперэйшн Групп Компани”
Баталгаажуулсан байгууллага, огноо:	Завхан аймгийн Стандарт хэмжил зүйн газар 2025 оны 07 сарын 01-ний өдөр
Тоолуурын заалт:	00001 м³ /2025 оны 07-р сарын 01-ний заалт/

2.9. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

2.9.1. Далангийн ул хөрс нягтруулахад ашиглах усны төлбөр

$1675 \times 0.5 = 837.5$ /итгэлцүүр/
 $9300 \text{ м}^3 \times 837.5 = 7,788,750.0$ ₮
 $7,788,750.0 \text{ ₮} \times 0.1 = 778,875.0$ ₮

2.9.2. Зам талбайн усалгаа

$1675 \times 0.5 = 837.5$ /итгэлцүүр/
 $2000 \text{ м}^3 \times 814.8 = 1,675,000.0$ ₮
 $1,675,000.0 \text{ ₮} \times 0.1 = 167,500.0$ ₮

2.9.3. Далангийн дүүргэлтийн ажилд ашиглах усны төлбөр

$1675 \times 0.5 = 837.5$ /итгэлцүүр/
 $15120 \text{ м}^3 \times 837.5 = 12,663,000$ ₮
 $12,663,000 \text{ ₮} \times 0.1 = 1,266,300.0$ ₮

2.9.4. Төмөр бетон гүүр болон хоолойн цутгалт

$1675 \times 1 = 837.5$ ₮
 $4200 \times 837.5 = 3,517,500.0$ ₮
 $3,517,500.0 \text{ ₮} \times 0.1 = 351,750.0$ ₮

2.9.5. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд

$2716 \times 0.2 = 543.2$ ₮
 $1390.2 \text{ м}^3 \times 543.2 = 755,156.64$ ₮
 $755,156.64 \text{ ₮} \times 0.15 = 113,273.5$ ₮



Нийт төлбөр: $778,875.0 + 167,500.0 + 1,266,300.0 + 351,750.0 + 113,273.5 = 2,677,698.5$
/ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ/ Завхан аймгийн Төрийн сангийн 1165117377 тоот дансанд төвлөрүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.18, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1. ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2. аль нэг тал татан буугдсан бол.

4.5.3. ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй;

4.5.4. байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн;

4.5.5. ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй;

4.5.6. усны эх үүсвэрийг бохирдуулсан;

4.5.7. усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

4.5.8. сав газрын захиргааны шийдвэрээр;

4.6. Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

.....
/Хяргас нуур-Завхан голын сав газрын
захиргааны ахлах мэргэжилтэн
Тогтохсүрэн овогтой Даваажаргал/

Ус ашиглагчийг төлөөлж:

.....
"Чайна Жиангсу Интернэйшнл Экономик
энд Техникал Кооперэйшн Групп
Компани"-ийн Ерөнхий инженер Ду
Ганглин /

Харилцах утас: 99736665

Харилцах утас: 88835000